

# МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

## 2024 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН



УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ТАМГЫН ГАЗАР

2025 ОНЫ 01 ДҮГЭЭР САРЫН 15-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

# ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

АЖ ҮЙЛДВЭРЖИЛТИЙН БОДЛОГЫН  
БАЙНГЫН ХОРОО

## ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дээрх  
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН  
2024 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ  
АЖ ҮЙЛДВЭРЖИЛТИЙН БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ  
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН  
АГУУЛГА

2025 оны 01 дүгээр сарын 15-ны өдөр, Лхагва гараг

|    |                                                                                                                                                                                                                                                                         |         |
|----|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|---------|
|    | <i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>                                                                                                                                                                                                                                  | 1       |
|    | <i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>                                                                                                                                                                                                                                       | 2 – 3   |
|    | <i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>                                                                                                                                                                                                                                | 4 – 55  |
| 1. | <i>Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хуулийн хэрэгжилт болон дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн эх үүсвэрийн бүрдүүлэлт, зээл олголт, эргэн төлөлт, зээлийн хэрэгжилт, үр дүнгийн талаарх Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын мэдээллийг сонсох</i> | 5 – 52  |
| 2. | <i>Байнгын хорооны тогтоолын төсөл /Ажлын хэсэг байгуулах тухай/</i>                                                                                                                                                                                                    | 52 – 55 |

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганы  
Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны  
2025 оны 01 дүгээр сарын 15-ны өдөр /Лхагва гараг/-ийн  
хуралдааны товч тэмдэглэл**

Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны дарга С.Ганбаатар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

*Хуралдаанд ирвэл зохих 23 гишүүнээс 12 гишүүн хүрэлцэн ирж, 52.2 хувийн ирцтэйгээр хуралдаан 18 цаг 31 минутад Төрийн ордны “Их засаг” танхимд эхлэв.*

*Чөлөөтэй: Д.Батлут, Д.Бум-Очир, Д.Жаргалсайхан, С.Лүндэг, П.Мөнхтулга, Д.Пүрэвдаваа, Б.Тулга, Б.Уянга.*

***Нэг.Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хуулийн хэрэгжилт болон дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн эх үүсвэрийн бүрдүүлэлт, зээл олголт, эргэн төлөлт, зээлийн хэрэгжилт, үр дүнгийн талаарх Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын мэдээллийг сонсох***

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ж.Энхбаяр, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Т.Жамбалцэрэн, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Жижиг, дунд үйлдвэрийн газрын дарга Я.Эрдэнэсайхан, Жижиг, дунд үйлдвэрийн газрын Зээл, тусгай активын хэлтсийн дарга Н.Энхтөр, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын шинжээч Э.Сугарбаяр нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хорооны ажлын албаны Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, референт Г.Баярмаа нар байлцав.

Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хуулийн хэрэгжилт болон дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн эх үүсвэрийн бүрдүүлэлт, зээл олголт, эргэн төлөлт, зээлийн хэрэгжилт, үр дүнгийн талаарх мэдээллийг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ж.Энхбаяр, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Жижиг, дунд үйлдвэрийн газрын дарга Я.Эрдэнэсайхан нар танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтуяа, С.Замира, М.Бадамсүрэн, Х.Жангабыл, Г.Очирбат, Б.Пунсалмаа, Г.Лувсанжамц, Л.Ганзориг, С.Ганбаатар нарын тавьсан асуултад Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ж.Энхбаяр, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Жижиг, дунд үйлдвэрийн газрын дарга Я.Эрдэнэсайхан нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Д.Үүрийнтуяа, Г.Очирбат, Г.Лувсанжамц, С.Замира, С.Ганбаатар нар үг хэлэв.

Улсын Их Хурлын гишүүд Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хуулийн хэрэгжилт болон дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн эх үүсвэрийн бүрдүүлэлт, зээл олголт, эргэн төлөлт, зээлийн хэрэгжилт, үр дүнгийн талаарх Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын мэдээллийг сонсов.

*Уг асуудлыг 20 цаг 28 минутад хэлэлцэж дуусав.*

**Хоёр.Байнгын хорооны тогтоолын төсөл /Ажлын хэсэг байгуулах тухай/**

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хорооны ажлын албаны Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, референт Г.Баярмаа нар байлцав.

“Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг Байнгын хорооны дарга С.Ганбаатар танилцуулав.

**С.Ганбаатар:** “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг баталъя гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9  
Татгалзсан: 6  
Бүгд: 15  
60.0 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

*Уг асуудлыг 20 цаг 34 минутад хэлэлцэж дуусав.*

Байнгын хорооны хуралдаанаар 2 асуудал хэлэлцэв.

*Хуралдаан 2 цаг 04 минут үргэлжилж, 23 гишүүнээс 15 гишүүн хүрэлцэн ирж, 65.2 хувийн ирцтэйгээр 20 цаг 35 минутад өндөрлөв.*

**Тэмдэглэлтэй танилцсан:**

АЖ ҮЙЛДВЭРЖИЛТИЙН БОДЛОГЫН  
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

С.ГАНБААТАР

**Тэмдэглэл хөтөлсөн:**

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ  
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

Ц.АЛТАН-ОД

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 оны 01 дүгээр сарын 15-ны өдөр, Лхагва гараг  
Төрийн ордны “Их засаг” танхим  
18 цаг 31 минут

### АЖ ҮЙЛДВЭРЖИЛТИЙН БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

**С.Ганбаатар:** Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганы 2025 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны хуралдаан эхэлснийг мэдэгдье.

Та бүхэндээ ирцийн талаар танилцуулъя.

Ирцэд Сайнхүүгийн Ганбаатар 1 дүгээр тойргоос ирсэн байна, М.Бадамсүрэн гишүүн 6 дугаар тойрог ирсэн байна, Далайн Батбаяр гишүүн 5 дугаар тойрог ирсэн байна, Цэрэнпилийн Даваасүрэн гишүүн 4 дүгээр тойрог ирсэн байна, Х.Жангабыл гишүүн 3 дугаар тойрог ирсэн байна, С.Замира гишүүн ирсэн байна, Г.Лувсанжамц гишүүн ирсэн байна, Л.Мөнхбаясгалан гишүүн 7 дугаар тойрог ирсэн байна, Г.Очирбат гишүүн ирсэн байна, Б.Пунсалмаа гишүүн ирсэн байна, Д.Энхтуяа гишүүн ирсэн байна, М.Энхцэцэг гишүүн ирсэн байна.

Нийт гишүүдийн ирц хангалттай. 52.2 хувь хүрсэн учраас хуралдаан эхэлснийг мэдэгдье.

Өнөөдрийн хэлэлцэх асуудал. Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хуулийн хэрэгжилт болон Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн эх үүсвэрийн бүрдүүлэлт, зээл олголт, эргэн төлөлт, зээлийн хэрэгжилт, үр дүнгийн талаарх Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын мэдээллийг сонсоно.

Энэ бол Монголын ард түмэнд том том уул уурхай, том том бүтээн байгуулалтуудаа бид хүндэтгэж байна. Ярьж байгаа ч яг нийт ард иргэдэд хамгийн чухал гол асуудлыг бас өнөөдөр ингэж мэдээлэл сонсох учраас гишүүд нэлээн идэвхтэй оролцох хэрэгтэй.

Ажлын хэсгийг байгаа. Ажлын хэсгийг Та бүхэнд танилцуулъя.

Хоёрт нь, “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоол бас эндээс гарна шүү.

Хэлэлцэх асуудал дээр саналтай гишүүд байна уу? Хэлэлцэх асуудлыг баталлаа.

---

**Нэг.Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хуулийн хэрэгжилт болон дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн эх үүсвэрийн бүрдүүлэлт, зээл олголт, эргэн төлөлт, зээлийн хэрэгжилт, үр дүнгийн талаарх Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын мэдээллийг сонсох**

---

Ингээд Улсын Их Хурлын гишүүн М.Бадамсүрэнгээс гаргасан хүсэлтийн дагуу Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хуулийн хэрэгжилт болон Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн эх үүсвэрийн бүрдүүлэлт, зээл олголт, эргэн төлөлт, зээлийн хэрэгжилт, үр дүнгийн талаар Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын мэдээллийг сонсоно.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг Та бүхэнд танилцуулъя.

Ж.Энхбаяр Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд ирсэн байна, Т.Жамбалцэрэн Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга ирсэн байна, Э.Сугарбаяр Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын шинжээч ирсэн байна, Я.Эрдэнэсайхан Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Жижиг, дунд үйлдвэрийн газрын дарга ирсэн байна, Н.Энхтөр Жижиг, дунд үйлдвэрийн газрын Зээл, тусгай активын хэлтсийн дарга ирсэн байна.

Ингээд дээрх мэдээллийг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Жадамбаагийн Энхбаяр танилцуулна.

**Ж.Энхбаяр:** Эрхэм гишүүдийнхээ амрыг эрье.

Монгол Улс, Америкийн Нэгдсэн Улсын Засгийн газар хооронд анх 1992-1993 онд гэрээ байгуулж Америкийн Нэгдсэн Улсаас Монгол Улсад хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний тусламж үзүүлэх тухай хэлэлцээрийн дагуу анх тусламжийн шар тос, цөцгийн тос нийлүүлсэн байдаг.

Түүний борлуулалтын орлогоос жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих чиглэлээр зарцуулахаар 1993 онд Худалдаа, үйлдвэрийн яамны дэргэд Жижиг, дунд үйлдвэрийн хэлтэс нэртэйгээр анх зохион байгуулагдаж энэ жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих ажил эхэлсэн ийм түүхтэй байдаг юм байна.

Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах жижиг, дунд үйлдвэрийн зориулалттай тоног төхөөрөмжийн гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх, бизнес инкубацыг эрх зүйн орчныг нь бүрдүүлэх, ахуйн үйлчилгээний салбар нэлээн хоцрогдсон гэж үзэж ахуйн үйлчилгээний салбарын мэргэжилтэй ажилтныг үнэлэх, бэлтгэх, зэрэглэлд олгох, тогтоох журмыг боловсронгуй болгох, жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийн бүтээгдэхүүнийг борлуулалтаар, төрийн худалдан авалтаар дэмжих стратегийг боловсруулах, орон нутгийн санхүүжилтийг шийдвэрлэх замаар Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн эх үүсвэрийг нэмэгдүүлж, орон нутгийн жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг хөнгөлөлттэй зээл олгох, орон нутагт ахуйн үйлчилгээний цэгийг байгуулах, иргэдэд ахуйн төрлийн үйлчилгээг ойртуулах, төрийн худалдан авалтыг нэмэгдүүлэх чиглэлээр арга хэмжээ зохион байгуулах, экспортод чиглэсэн жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдэд санхүүгийн дэмжлэг батлан даалт болон бусад төрлийн төрийн дэмжлэгийг үзүүлэх, кластераар бүслэн хөгжүүлэх чиглэл батлах тухай Засгийн газрын тогтоолд жижиг, дунд үйлдвэрийн хөгжлийн бодлогыг тусгах, Зээлийн батлан даалтын сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах ийм зорилтыг Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт Улсын Их Хурлаар батлуулаад, энэ зорилтыг хэрэгжүүлэхээр 2020 онд жижиг, дунд үйлдвэрийн газар буюу Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг болж шинэ зохион байгуулалтад орсон.

Одоо 4 жил 4 сар ажиллаж байгаа энэ агентлаг саяын тавьсан дээрх үүргийг хэрэгжүүлэхээр ингээд ажиллаж байгаа юм.

Ингээд өмнөх Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан болон өмнө нь олгогдсон зээл, ер нь хэрэгжүүлж байгаа бодлого, үйл ажиллагаатай холбоотой дэлгэрэнгүй танилцуулгыг Жижиг, дунд үйлдвэрийн газрын дарга Я.Эрдэнэсайхан дэлгэц дээр танилцуулна. Хүлээж авна уу. 4 номер.

**С.Ганбаатар:** Я.Эрдэнэсайхан дарга танилцуулгаа хийе. 4 номерын микрофон.

**Я.Эрдэнэсайхан:** Та бүхэндээ оройн мэнд хүргэе.

Жижиг, дунд үйлдвэрийн тухай хуулийн хэрэгжилт, тэгээд сангийн үйл ажиллагаатай холбоотой танилцуулгыг 4 агуулгын хүрээнд хууль эрх зүйн орчин, статистик тоо баримт, газар буюу сангийн үйл ажиллагаа, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээ гэсэн агуулгад Та бүхэнд танилцуулъя.

Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хууль Засгийн газрын тусгай сангийн хууль, Хоршооны тухай хууль, Зээлийн батлан даалтын сангийн тухай хууль, Компанийн тухай хууль, Нөхөрлөлийн тухай хууль зэрэг гол хуулиудын хүрээнд зохицуулагдаж байгаа. Эрх зүйн орчин нь.

Энэ дотроосоо Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хууль маань хамгийн гол зорилго нь ажлын байрыг нэмэгдүүлэх, эдийн засагт эзлэх хувь оролцоог нь дээшлүүлэх гол зорилготой.

Энд үйлдвэр, худалдаа, үйлчилгээний салбар бүгд орж байгаа. Хуулиараа 200 хүртэл ажилтантай, жилийн 2.5 тэрбум төгрөг хүртэлх борлуулалтын орлоготой байх юм бол жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгч гэж үзэж байгаа.

Дотоодын аж ахуйн нэгжүүд орно. Ер нь Монгол Улсад үйл ажиллагаа явуулж байгаа нийт аж ахуйн нэгжүүдээс архи, тамхи худалдах, үйлдвэрлэх, уул уурхай гэсэн тодорхой цөөхөн чиглэлээс бусад бүхий л үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжүүд жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчид гэсэн салбарт хамаарч байгаа.

Төрийн бус байгууллага, төрийн байгууллага, гадаадын хуулийн этгээд энд хамаарахгүй.

Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хуульд бичил, жижиг, дунд гэж яг олон улсын аргачлалынх нь дагуу 3 хувааж ангилсан.

▷ Бичил үйлдвэр, үйлчилгээ эрхлэгч гэдэг нь 10 хүртэл ажилтантай, 300 сая хүртэл төгрөгийн борлуулалтын орлоготой бол **“бичил”**.

▷ 10-аас 50 хүртэл ажилтантай, 300-аас 1 тэрбум төгрөгийн борлуулалтын орлоготой бол **“жижиг үйлдвэр эрхлэгч”**.

▷ 50-иас 200 хүртэл ажилтантай, 1-ээс 2.5 тэрбум төгрөгийн борлуулалтын орлоготой бол **“дунд үйлдвэр эрхлэгч”** гэж хуульчилж ангилсан байгаа.

Ингэж 3 дотор нь жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчээ ангилж байгаа.

Энэ хуулийн хүрээнд Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас зээл олгох, эргэн төлүүлэх, сонгон шалгаруулах, хяналт тавих журмыг 2020 онд Засгийн газрын 113 дугаар тогтоолоор баталсан. Үүнээс өмнө энэ журам маш олон удаа өөрчлөгдсөн байдаг. Энэ журам өнөөдрийг хүртэл тогтвортой хэрэгжиж байгаа.

Мөн жижиг, дунд үйлдвэрийн газарт хоршооны асуудал бас хамаардаг.

Тэгэхээр бид Хоршоо хөгжүүлэх сангаас зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журмыг мөн Монгол Улсын Засгийг газраар батлуулж өнөөдөр хүртэл хэрэгжиж байгаа.

Энэ хүрээнд сум болгон дээр байдаг Хоршоо хөгжүүлэх сан, удирдлага зохион байгуулалтад сумын Засаг дарга хийдэг. Энэ сангийн нэгдсэн удирдлага, зохион байгуулалтыг хангаж, журмыг боловсруулж, Монголбанкны зээлийн мэдээллийн санд тогтмол нийлүүлж ажилласнаар Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Жижиг, дунд үйлдвэрийн газрын эрхэд чанаргүй зээлийн хувь 79 байсныг бид өнөөдрийн байдлаар 39 хүртэл бууруулаад дахин бууруулах чиглэлээр хичээж ажиллаж байна.

Мөн жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг 300 сая хүртэл борлуулалтын орлоготой бол 1 хувийн татвар төлдөг хууль татварын хуулиар гарсан. Мөн тайлангаа жилд 2 удаа хялбарчилсан байдлаар гаргах ийм татварын өөрчлөлт орсон байгаа.

Мөн Хоршооны тухай хуулийг 2021 онд батлуулж, энэ хүрээнд Их Хурлын тогтоол гаргаж ажилласан.

Мөн Монгол Улсын Засгийн газрын санаачилгаар 2025 оныг Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий ассамблейгаар Олон улсын хоршооллын жил болгож зарлуулсан байгаа.

Энэ хүрээнд жишээлбэл жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн үндсэн хөрөнгөд элэгдэл тооцох хугацааг 25 жил, алдагдалд шилжүүлэх хугацааг 4 жил, үндсэн хөрөнгийн худалдан авалтаас НӨАТ-ын хасалт хийх, алслагдсан байх юм бол 500 километрээс дээш бол 50 хувь, 1000 километрээс дээш байх юм бол 90 хувийн татварын хөнгөлөлт үзүүлж байгаа.

Мөн тодорхой салбар буюу үр тариа, төмс, хүнсний ногоо гэх мэт 6 салбарт 50 хувийн хөнгөлөлтийг үзүүлж байгаа ийм орчныг бүрдүүлж чадсан.

Мөн Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль дээр бас нэлээдгүй зохицуулалтуудыг оруулж өгсөн байдаг. Энэ хүрээнд дотоодын үйлдвэр буюу жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдээс бараа, бүтээгдэхүүнээ худалдан авах юм бол 15 хувиар хийсвэрлэн бууруулах, заавал дотоодын үйлдвэрийг тендер шалгаруулалтын баримт бичигт оруулах, давуу эрх олгох гэсэн ийм зохицуулалтуудыг энэ хуульд оруулж өгсөн байгаа.

2023 оны жилийн эцсийн байдлаар Үндэсний статистикийн хорооны мэдээгээр жижиг, дунд үйлдвэрийн салбарт 253 мянга 95 хүн ажиллаж байгаа.

Аж ахуйн нэгжийн хувьд 76561 ажиллаж байна. Үүнээс Улаанбаатар хотод 55 мянга, орон нутагт 21 мянган жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчид байна.

Үүнийг 2017 оноос хойших 2023 он хүртэлх бичил, жижиг, дунд нь хэд байна вэ гээд аваад үзсэн. Нийтдээ 76 мянган жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчийн 71 мянга нь буюу 90 хувь нь бичил, 4800 нь жижиг, 163 нь л дунд гэсэн ийм ангилалд байгаа.

Жижиг, дунд үйлдвэрийн газар. Түрүүн сайд хэлсэн. 2020 онд байгуулагдсан. Ингээд өмнө нь байсан асуудлуудыг нэлээн цэгцэлж ажиллаж байгаа. Энэ хүрээндээ бид Хууль, тусгай активын хэлтсийг байгуулж, өмнө олгогдсон байсан зээлийн эргэн төлөлтийг төлүүлэх талаар хууль хяналтын байгууллагад нэлээдгүй хандаж ажиллаж байгаа.

Жижиг, дунд үйлдвэрийн тухай хууль дээр санхүүгийн болон санхүүгийн бус ийм ийм дэмжлэгийг үзүүлнэ гэсэн ийм зохицуулалтууд байгаа.

Энэ дотор хөнгөлөлттэй зээл олгох, зээлийн хүүгийн хэмжээг бууруулах, батлан даалт гаргах, хүүгийн татаас олгох, тоног төхөөрөмжийн түрээсийн үйлчилгээ үзүүлэх, түрээсийн үйлчилгээний хүүгийнх нь дэмжлэгийг үзүүлэх гэх мэт ийм зохицуулалтууд орсон.

Санхүүгийн бус дэмжлэг дотроо экспортыг нэмэгдүүлэх, импортыг орлох ийм бүтээгдэхүүн үйлчилгээг дэмжих, төрийн худалдан авалтаар дэмжлэг үзүүлэх, бизнесийн зөвлөх үйлчилгээ үзүүлэх, шинэ бүтээгдэхүүний судалгааг дэмжих, техник технологийг нутагшуулах, судалгааны үр дүнг үйлдвэрлэлд нэвтрүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх, кластер хэлбэрээр үйл ажиллагаа явуулж байгаа орон нутгийн үйлдвэрлэгчдийг дэмжих, гадаад, дотоод зах зээлд нэвтрэхэд нь дэмжлэг үзүүлэх, дотоодын болон олон улсын үзэсгэлэн худалдаа зохион байгуулах оролцоход дэмжлэг үзүүлэх ийм хууль эрх зүйн дэмжлэгүүдийг тусгаж өгсөн байгаа.

Энэ салбарын хувьд дээрх дэмжлэгүүдийг жишээ нь Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас зээл олгох, Зээлийн батлан даалтын сангаас батлан даалт гаргах, Хоршоо хөгжүүлэх сангаас орон нутагтаа шийдвэрээ гаргаад дэмжлэг үзүүлэх, Засгийн газрын болон олон улсын төсөл хөтөлбөрүүдээр хамрагдуулах ийм санхүүгийн дэмжлэгүүдийг үзүүлж байгаа.

Санхүүгийн бус дэмжлэг дотор зөвлөх үйлчилгээ, көучинг сервис, бизнес инкубатор төвүүдээр дамжуулж дэмжлэг үзүүлэх, хүний нөөц болон сургалтуудыг хийх, борлуулалт, маркетинг, зах зээлд нэвтрэхэд нь дэмжлэг үзүүлэх гэсэн ийм багц хүрээнд дэмжлэгүүдийг үзүүлж ажиллаж байгаа.

Жижиг, дунд үйлдвэрийн газрын зүгээс бас гадаад донор байгууллагууд, гадаад зах зээл рүү нэвтрэхийг нэлээн хичээж ажиллаж байгаа.

Энэ хүрээндээ Европын Сэргээн Босголт, Хөгжлийн Банк, олон улсын хөгжлийн байгууллагуудтай хамтарч ажиллаж байна. Ингээд бас бүх үйл ажиллагаагаа цахимжуулсан байгаа. Энэ хүрээндээ Европын Сэргээн Босголт, Хөгжлийн Банкны дэмжлэгтэйгээр вебсайтаа шинэчлэх, энэ сонгон шалгаруулалтыг цахим болох гэх ажлуудыг хийсэн.

Мөн Канадын мерит хөтөлбөртэй хамтраад 4 аймаг дээр уул уурхайн байгууллагууд, компаниудад жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн орон нутгийн жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн бүтээгдэхүүнийг нийлүүлэх ажлыг хамтарч зохион байгуулсан.

Мөн Европын Сэргээн Босголт, Хөгжлийн Банктай энэ ковидын үед онлайн сургалтуудыг хийгээд цахимаар хүргэсэн байгаа.

Дэлхийн банкны экспортыг дэмжих төслийг бас сонгон шалгаруулалтыг хийж олон аж ахуйн нэгжүүдэд грант олгосон. Гэх мэтчилэн олон байгууллагуудтай хамтарч ажилласан.

Энэ хүрээндээ бид бас зээл олгохоос гадна энэ Жижиг, дунд үйлдвэрийн газар Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн ажлын албаны үүргийг давхар гүйцэтгэж байгаа. Өөрөөр хэлбэл нэг бүтцээр хоёр байгууллагын үйл ажиллагааг хариуцаж ажиллаж байгаа.

Тэгэхээр зээл олгохоос гадна бас борлуулалтыг дэмжих зах зээлд нэвтрэхэд нь дэмжлэг үзүүлж дотоод, гадаадын үзэсгэлэнг зохион байгуулдаг. Энэ хүрээндээ “Намрын ногоон өдрүүд”, “Монголд үйлдвэрлэвэл”, “Цагаан сар”, “Улаанбаатар түншлэл”, “Олон улсын жижиг, дундын өдөр”, “Төрийн худалдан авалт” гэх мэтчилэн нийтдээ 4 жилийн хугацаанд 25 үзэсгэлэн, арга хэмжээг зохион байгуулж, 2300 жижиг, дунд үйлдвэрлэл үйлдвэр эрхлэгчид оролцож, 13 тэрбум төгрөгийн борлуулалтыг хийсэн байна.

Мөн олон улсад буюу Бүгд Найрамдах Солонгос Улс, Америк, Канад гэх мэтчилэн улсуудад 20 удаагийн тухайн улсуудад болдог үзэсгэлэн болон бие даасан үзэсгэлэнг зохион байгуулж 1000 гаруй үйлдвэрлэгчдийг оролцуулсан. Гурван улсад Америкийн Нэгдсэн Улс, Хятад, Герман зэрэг улсуудад байнгын үйл ажиллагаатай дэлгүүрийг нээж.../минут дуусав/

**С.Ганбаатар:** Ингээд жижиг, дунд үйлдвэрлэлийн үйл ажиллагааны талаар Я.Эрдэнэсайхан Засгийн газрын хэрэгжүүлэх агентлагийн Жижиг, дунд үйлдвэрийн газрын дарга мэдээлэл өглөө.

Энэ хуульдаа 10 минутаар мэдээлэл өгөх ёстой шүү. Хойшид анхаарахдаа гол гол зүйлүүдээ хэлбэл их сайн.

Тэгээд чин үнэнийг хэлэхэд жижиг, дунд үйлдвэрлэлийн асуудлаар энэ агентлаг сайн ажиллаж байгаа. Хамгийн шударга ажиллаж байгаа гэдгээр сүүлийн 3 жил төрийн үйлчилгээний газруудаас нэгд нь байгаа. Олон зүйлүүд сайн байгаа.

Хамгийн гол нь та нарт гишүүд өнөөдөр яаж энэ жижиг, дундыг хөгжүүлэх вэ, дэмжих вэ гэж ирсэн байхад та нар яг гол гол асуудлаа ярихгүй бол. Одоо Улсын Их Хурал бид төсөв дээр юу ч баталж өгч чадсангүй гэдэг дээр ингэмээр байна, тэгмээр байна гэдэг ийм ажил хэргийн юм яривал их сайн байгаа шүү.

Ингээд асуултад хариулахдаа тойрохгүйгээр гол гол ажил хэрэгч асуудлуудыг яривал буян болно гэж би ойлгож байна.

Мэдээлэл хийсэн Я.Эрдэнэсайхан даргад баярлалаа. Одоо ингээд асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү?

С.Замира гишүүнээр, П.Ганзориг гишүүнээр асуулт асуух гишүүдийн нэрсийг тасалъя. Ингээд Д.Энхтуяа гишүүн асуулт асууна.

**Д.Энхтуяа:** Та бүхэнд оройн мэнд хүргэе. Ингээд танилцуулга хийсэн төрийн албан хаагчдадаа баярлалаа.

Тэгээд Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн асуудлаар жижиг, дунд үйлдвэрлэл эрхэлж байгаа хүмүүс болон ард иргэд бол маш сайн мэднэ.

Тэгээд сая бас Байнгын хорооны дарга хэллээ. Ер нь хамгийн сайн ажиллаж байгаа сан гээд тэгж байна. Тийм ээ.

Тэгэхээр үйлдвэрлэгчдэдээ энэ сангаар дамжуулаад хөрөнгө оруулалт, зээл авах боломж нь бас нэлээн гарч байгаа. Харамсалтай нь өнөөдөр жижиг, дунд үйлдвэрлэл эрхэлж байгаа хүмүүсийн бүтээгдэхүүн хөгжүүлэлт болон тоног төхөөрөмжөө шинэчлэх боломж нь маш бага байна гэсэн гомдлыг хэлдэг.

Нэг удаагийн зээл аваад ямар ч байсан үйл ажиллагаагаа эхлээд ингээд үйлдвэрлэлээ явуулчихдаг. Дахин дахин тоног төхөөрөмжөө сайжруулах, бүтээгдэхүүнээ хөгжүүлэх, тэгээд улмаар хоёр хөршийнхөө ядаж зах зээлд гарах энэ боломж чинь маш хомсдмол байна гэсэн ийм л зүйлийг жижиг, дунд үйлдвэрлэгчид маань хэлдэг.

Жил болгон Сүхбаатарын талбай жижиг, дунд үйлдвэрлэгчдийн үзэсгэлэн худалдаа гардаг. Ерөнхийдөө харж байхад манай энэ жижиг, дунд

үйлдвэрлэлийн эрхэлж байгаа хүмүүсийн бүтээгдэхүүн хөгжүүлэлт маш муу байдаг.

Тэгэхээр дараа дараагийн зээлд хамрагдах боломж нь хэр байдаг юм бэ? Жижиг, дунд үйлдвэрлэл хөгжүүлэх энэ сангаас.

Хоёрдугаар асуулт бол энэ шинээр хийгдэх зүйл дээр энэ кластерын хэлбэрээр үйл ажиллагаа явуулах тохиолдол тэдгээрийг дэмжинэ. Ялангуяа орон нутагтаа энэ дэмжлэгийг их өгнө гэж байна.

Тэгэхээр энэ дээр яг судалгаа хийсэн үү? Яг кластер хэлбэрээр ямар ямар үйлдвэрлэлийг дэмжих, аль бүсэд нь илүү кластер хэлбэрээр дэмжих боломж байгаа гэдэг судалгаа Та бүхэн хийсэн үү? Энэ судалгааныхаа үндсэн дээр аль бүсэд дэмжлэг илүү очих вэ? Одоо манай урд хөрш хойд хөрш ер нь энэ ядуурлаас гаргаж байгаа энэ процесс байнга л энэ хэвлэл мэдээллээр явж байна л даа.

Тэгэхээр эхлээд жижиг, дунд үйлдвэрлэл эрхэлж байгаа хүмүүстээ зээл өгчихдөг. Гэтэл дахиад нөгөө жижиг, дунд үйлдвэрлэл эрхэлсэн хүмүүс маань ядуучуудын эгнээнд эргэж очоод, нөгөө бүтээгдэхүүнийг авах хооронд нь уялдаа холбоог нь суулгаж өгөөгүйгээс болоод дампуурах эрсдэл байна. Тийм учраас бас төрийн зохицуулалт гэдэг юм уу, бодлогоор дэмжиж өгдөг.

Тэгэхээр бодлогын бичиг баримт орж ирж байна гэж харж байна. Та бүхэн энэ дээрээ хэр зэрэг судалгаа хийсэн бэ? Яг бодитойгоор кластер хэлбэрээр хаана хаана хөгжүүлбэл жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчид маань илүү үйл ажиллагаа нь хэвийн, байнгын орлоготой. Тийм ээ. Нөгөө худалдан авч байгаа хүмүүс нь ч гэсэн бас яг байнгын орлогоо нөгөө хүмүүстээ өгчихдөг. Ингэж байж цаашдаа ядуурлаас гарах, дампуурдлоос гарах, эсвэл жижиг, дунд үйлдвэрлэл эрхэлж байгаа улс маань хаалгаа барьж байгаа энэ тохиолдлоосоо гарах ийм боломж нь харагдаж байгаа юу? Энэ дээр нэлээн судалгаа хийсэн болов уу гэж бодож байна. Ингээд хоёр асуултад хариулж өгнө үү.

**С.Ганбаатар:** Д.Энхтайван гишүүний асуултад сайд хариулах уу? 5 номерын микрофон.

**Ж.Энхбаяр:** Үндсэндээ энэ салбарт нийт ажлын байрны 2 хүний нэг буюу 600 мянган хүн энэ хүнс, хөдөө аж ахуйн салбарт хамрагдаж байгаа. 90 хувь нь жижиг, дунд үйлдвэрлэл. Үндсэндээ.

2025 оны Улсын Их Хурлын төсөвт эх үүсвэр тавигдаагүй. Жижиг, дунд үйлдвэрийн агентлагийн урсгал зардал болон хөрөнгө оруулалт, зээл төсөвт суугаагүй буюу эргэн төлөлт буюу өмнө олгосон зээлийн эргэн төлөлтөөс

өөрийгөө санхүүжүүлээд саяын энэ нэр дурдсан бизнесийг дэмжих, идэвхжүүлэх арга хэмжээгээ авч зохион байгуулалт хийгээд зээл олгоно.

Бид тусгай активын газрыг байгуулаад сүүлийн хагас жилд бид зээлийн эргэн төлөлтийг нэлээн хатуу чангалж байгаа. Монголбанктайгаа маш сайн нягт ажиллаж байгаа буюу тэр мэдээллийн сангуудыг бүх зээл, бүх дэмжлэг, бүх хөнгөлөлт, бүх асуудал дээр манайд өртэй аж ахуйн нэгжүүд, иргэдийн тоо гарч ирж зээлийг шахаж эхэлж байгаа.

Түүнтэй холбоотойгоор зээлийн эргэн төлөлт нэлээн идэвхэжсэн. Ингээд бид 2025 онд улсын хэмжээнд 40 тэрбум төгрөгийн зээлийг жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчид олгохоор боломжийг бүрдүүлж байгаа.

Нөгөө талаар жижиг, дунд үйлдвэрийн сан маань Засгийн газрын бонд, Хөгжлийн банк, арилжааны банкны зээл гээд ийм эх үүсвэр байсан. Гадаадын зээл, тусламжийн эх үүсвэр байсан. Энэ эх үүсвэрийг 100 хувь бүрэн төлж дууссан. Одоо Жижиг, дунд үйлдвэрийн газар бусдад төлөх ямар нэгэн үүрэг хариуцлага байхгүй. Байгаа бүрдсэн эх үүсвэрээсээ бид олгосон зээлээсээ эх үүсвэрээ бүрдүүлээд зээл олгоно. Ирэх онд. 40 тэрбум гэсэн том зорилт тавьсан. Тэгээд үүнийгээ хэрэгжүүлэхийн төлөө явна.

Үүнийгээ 21 аймаг, нийслэл, Улаанбаатар гээд хүргэхээр үндсэндээ нэг аймгуудад тэрбум тэрбум орчим төгрөгийн л эх үүсвэр очиж чадаж байгаа. Сумд бол бараг хүрч чадахгүй байгаа.

Үнэхээр нутаг орондоо ажилтай, хөдөлмөрчтэй, орлоготой байхад энэ жижиг, дунд энд зээлийн бодлого үнэхээр ус агаар ч хэрэгтэй байгаа.

Энэ чинь жилийн 3 хувийн хүүтэйгээр 5 хүртэл жил өгч байсан зээл шүү дээ. Одоо эх үүсвэр багассан. Одоо бид жилийн 5 хувиар олголтын зээлийн хэмжээг нь хугацааг нь жоохон богиносгохоос аргагүй байдалд үүсэж байгаа. Дутмаг байгаа. Хүрэлцээ байхгүй байгаа. Тэгээд байгаа хэмжээндээ зохицуулалтуудыг хийж байна. Жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх бодлого манай их тэргүүлэх чиглэл байх учиртай. Нутаг орондоо ажиллах, амьдрах гол нөхцөлийг бүрдүүлж байгаа зүйл.

Үнэхээр Д.Энхтуяа гишүүний хөндсөн шиг төвлөрүүлээд кластер хэмжээнд өгч чадахгүй байгаа юм. Одоо энэ хүснэгтээр олгосон зээлийн багц гарч байгаа. Энэ бол нийтлэгээр байгаа зээлүүд. Жижиг үйлдвэрлэл дээр л их яваад байгаа. Хүнсний болон хөнгөн үйлдвэрлэл дээр. Мал аж ахуй, газар тариалан үйлчилгээ гэсэн топ 5 салбар байгаа. Үнэхээр хүсэлт асар их. Асар их болохоор хэл ам ихтэй.

Тэгэхээр бид зээл олгох юмаа их ил тод, шилэн болгоод байнгын олон нийтийн гишүүн хяналт дор зохион байгуулсан. Сүүлийн 2 жил Авлигатай тэмцэх газраас хамгийн шалгаруулалт шударга болж байгаа, ил тод тод үйл ажиллагаа явж байгаа төрийн байгууллагууд батламж авсан байгаа.

**С.Ганбаатар:** Д.Энхтуяа гишүүн тодруулъя.

**Д.Энхтуяа:** Сайдын хариултаас зээл олгохдоо ч гэсэн тэр кластер маягаар олговол уг нь яг үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээ худалдан авагчдаа хүргээд. Тийм ээ. Тэгэхгүй бол зардал замын зардлаас авхуулаад нэлээн үнэтэй байдаг учраас нөгөө зээл авсан хүмүүс чинь ашигтай ажиллаж чадахгүй, тэгээд эргээд хаалгаа барихад хүрээд байгаа ийм дүр зураг харагдаад байгаа байхгүй юу.

Тэгэхээр Та бүхэн “кластераар хөгжүүлнэ” гэж шинээр оруулж байгаа. Үүнийг дэмжиж байна. Энэ бол маш зөв. Энэ бол жижиг, дунд үйлдвэрлэлийг жинхэнэ утгаар нь хөгжүүлэх төрийн бодлого гэж би харж байгаа юм.

Тэгэхээр Та бүхэн энэ дээрээ нэлээн сайн судалгаа хийж нарийвчилж оруулаарай гэж хүсэж байна даа.

**С.Ганбаатар:** Д.Энхтуяа гишүүний асуулт дээр зүгээр тодруулж хэлэхэд. Сайд хариулах байх. Д.Энхтуяа гишүүн маш чухал нэг ийм юм асуугаад байна шүү дээ.

Ингээд жижиг, дунд үйлдвэрлэлийн хөгжил гээд л ярихаар л аймаг ч юм уу, суманд ч юм уу дур дураараа хөөрхий тэгээд л нэг нарийн боов, мэддэг ганц нэг юмаа л, тэгээд л эсгий тапочки гээд л ингээд л явчих гээд байна.

Эд нарт шинжлэх ухааны үндэстэйгээр, тооцоо судалгаатайгаар, зах зээлийнх нь судалгааг нь хийчхээд Архангай аймгийн Чулуутад яг энэ цагаан идээний ийм ийм юм хийнэ шүү, ийм тоног төхөөрөмж, ийм зах зээлийн гарц байна, хүний нөөц нь ийм байна, технологийн шийдэл нь ийм байна гэдэг ийм газрын зургийг сум болгонд. Баян-Өлгий аймгийн Сагсай сумд ингэнэ гэсэн ийм шинжлэх ухааны үндэстэй газрын зураг байгаа юу? Байгаа бол бид үүнийг сум болгон дээрээ, Улаанбаатар хот болон Дархан Эрдэнэтэд бол баг болгон дээрээ авах сонирхолтой байна. Ийм зүйл байгаа гэдэгт би итгэлтэй байна. Бүхэл бүтэн яам байгаа. Тэгээд үүнийг бид өнөөдөр юм уу, эсвэл энэ долоо хоногтоо багтааж авч болох уу гэж би асууж байна гэж ойлгож байна.

Ингээд Ж.Энхбаяр сайд 5 номерын микрофон.

**Ж.Энхбаяр:** Тэгэхээр хэрэгцээ өндөр болохоор аймаг аймагт тэрбум хүрэхгүй төгрөг хуваарилж байгаа байдал маань өөрөө яг таны хэлдэг шүүмж дагуулж байгаа юм.

Унь болдог бол жишээ нь сүүн дээр гэхэд 10-аас 20 үнээтэй 20-оос 30 өрх нийлээд нэг сүүний кластер. Дунд нь боловсруулах цех. Ногоочид. 1 га хүртэл ногоо тарьж байгаа 20-оос 30 ногоочдыг нийлүүлээд нэг төрлийн ногоо тариад дунд нь боловсруулах, савлах үйлдвэр. Хүүхдийн тэжээлийн үйлдвэр байна уу. Ийм мэтчилэн зохион байгуулалтууд үнэхээр шаардлагатай байгаа.

Тэгэхээр бид хөрөнгийг жоохон төвлөрүүлэх болчихоод. Нөгөө жоохон эх үүсвэрээ ёстой урдаа барих уу, хойноо барих уу л болчихоод байгаа юм.

Тэгэхээр би Байнгын хорооноос ер нь кластераар хөгжүүлээ. Ингээд тэгшитгэн хуваарилах бодлогоос татгалзаад үр дүн гаргах тал руугаа ажилла гэвэл бид яг жишээ нь сүүн дээр их гоё жишээ байгаа юм. Ногоон дээр их гоё жишээ байгаа юм. Мөн хүлэмжийн аж ахуй эрхлэгчид дээр бас их гоё.

**С.Ганбаатар:** Тийм. Сайдын хариултыг ойлголоо.

Тэгэхээр мэдээж мөнгө санхүү төвлөрүүлэх тааруу байгаа. Энэ удаад жижиг, дунд үйлдвэрлэлийн санд хэдэн төгрөг гэж төсөвлөж яамнаас орж ирсэн юм.

Тэгээд Сангийн яаман дээрээ уначихсан юм уу. Ямар ч байсан Их Хуралд орж ирэхдээ хэд байсан юм.

Тэгээд мөнгө их тааруу байж болно. Мөнгөнөөс илүү технологийн хувьд, менежментийн хувьд, та нар зөвлөмжийн хувьд мөнгө өгч чадахгүй ч гэсэндээ Сагсай сумд, Чулуут сумд, эсвэл Баянхонгорын Баацагаанд юу хийж болох вэ, ийм зүйл хийвэл та нар Оросын, Хятадын, Японы зах зээл дээр гарах боломж байна. Ийм технологиор ийм хүний нөөцөө бэлдэнэ гэдэг энэ судалгаа өөрөө бидэнд их чухал байгаа. Энэ талаар бидэнд мэдээллийг хэдийд өгөх боломжтой вэ л гэж би тодруулж сонирхмоор байна.

Ингээд 5 номерын микрофон.

**Ж.Энхбаяр:** Ийм судалгаанууд бүр нутаг орон онцлогтой нарийвчлан гарах нэлээн ажлууд байгаа танилцуулъя.

Жишээлбэл, сүүлийн 6 жил улсын төсөв, хөрөнгө оруулалт нэг төгрөг ч аваагүй. Жижиг, дунд үйлдвэрийн сан бодлого авагдаагүй. Зөвхөн өөрөө өөрийгөө санхүүжүүлж өөрөө өөрийгөө үйл ажиллагаа явуул гэсэн.

2025 оны тухайд бид 100 тэрбум төгрөгийн эх үүсвэр шилжиж өгөөч гэсэн. Тэгээд шийдэгдээгүй. Ийм байдалтай байна. Үнэхээр сум суманд ижилхэн очихоор нөгөө л ижилхэн жижигхэн нөгөө хийдэг л модон тоглоом, эсгий, тапочки, нөгөө л ойр зуурын адилхан. Хоорондоо өрсөлдөх ямар ч чадавх байхгүй, зах зээл тэлэх бололцоогүй ийм байдал руу.

Бид нэг сум, нэг суурин, нэг бүтээгдэхүүн гэдэг бодлого руу л ормоор байгаа юм. Түүгээрээ бүр төрөлжиж, бүр онцгойрч, ялгарч. Жишээлбэл, сумаараа юу гэдэг юм лууван тарьдаг. Түүгээрээ хүүхдийн луувангийн тэжээл, хүүхдийн тэжээлийн тэр жүүс гаргадаг буюу нэгдсэн сум нэг бүтээгдэхүүн, нэг суурин газар нэг бүтээгдэхүүн рүү явах нь их зөв байна. Ер нь жижиг, дунд үйлдвэрлэл хөгжүүлсэн.../минут дуусав/

**С.Ганбаатар:** Ингээд С.Замира гишүүн асуулт асууя.

**С.Замира:** Баярлалаа. Уг нь энэ хэрэгжүүлэх гэж байгаа энэ юу бол их өгөөжтэй юм. Тэгэхдээ үр дүн нь яадаг бол?

Ер нь жижиг, дунд үйлдвэрийн юунаас нэлээд тэрбум тэрбумаар юу гардаг. Тэгэхдээ энэ нэг үр дүн гардаггүй юм. Урд жилүүдэд тийм байсан байна шүү дээ. Тийм үү? Яг түүнээс л болоод ажил албатай болсон, ядахдаа нэг масло. Маслийг бид тухайн үед өөрсдөө үйлдвэрлэдэг байсан шүү дээ. Оросоос авдаггүй. Өөрсдөө үйлдвэрлээд иддэг байсан юм. Сметан. Жишээлбэл. Одоо тиймэрхүү фермерийн маягаар юм уу, төрөлжүүлээд гадаадаас авахгүйгээр өөрсдөө хангахаар ямар нэг байдлаар хил хаагдлаа гэхэд ядахдаа өөрсдийн хувцас хунараа өөрсдөө оёж авчихаар, өөрсдийн нарийн ногоогоо эндээ идэж. Тийм байдалтай уг нь төрөлжүүлээд үүнийг нэг юу хийж ирээд нэг танилцуулж болох уу? Ийм сумууд, ийм аймагт ийм юм хиймээр байна, ийм санхүүжилттэй гээд.

Тэгээд тэрийг нь бас яваандаа өгчхөөд ингээд суухгүйгээр ингээд юугаар графикаар өгдөг шүү дээ. Эхний ээлжид үүнийг хий. Нөгөө хяналтаа тавиад. Өөрөө дутуу хийсэн байна. Үүнийг дуусгасны дараа хоёр дахь санхүүжилтээ хийнэ. Гэх шиг нэг эргэх холбоотой л байх хэрэгтэй. Тэгэхгүй бол ингээд л нэг зээл хүсээд ирсэн. Жижиг, дунд үйлдвэрлэлийг нь өгчихдөг. Нөгөөдөх нь хийх юм байхгүй тэгээд худалдаа наймаа болоод сүүлд тэгээд явж байгаа шүү дээ.

Сая Ж.Энхбаяр сайдын ярьж байгаа нь үнэн. Ядахдаа лууванг тарьж. Тэгээд лууванг нь гадаадаас авч байна шүү дээ. Бид нар. Их гоё сайхан цоог, тэгээд нөгөө юу гэдэг билээ нөгөө жоохон хүүхдүүдийн иддэг. Тиймэрхүү юмыг ядахдаа өөрснөө хангаж чадаж байвал болж байна шүү дээ. Нэг ч юм ч гэсэн.

Тийм учраас өгөөжтэй юм хийгээч ээ.

Тэгээд С.Ганбаатар даргын л ярьж байгаа нь бас зөв. Уг нь судалгаатай ийм газарт ийм юм хийе, энэ газарт энэ дутмаг байна гээд.

Тэгээд бид тухайн үед ахуйн үйлчилгээ гээд байсан шүү дээ. Тэр алга болсон уу? Энд тэнд нэг түрээсээр суудаг нэг түрээсийн байрны хэд оёдолчин хөөрхий нэг засвар хийсэн болоод нэг юм захиалгаар оёсон болоод сууж байна шүү дээ. Ер нь ахуйн үйлчилгээний салбарыг хэдүүлээ хөгжүүлэх гээд үзвэл яасан юм бэ? Гутал оёдог байсан. Тухайн үед. Одоо манай урд хөршөөс авсан гутал ерөөсөө хүмүүсийн хамгийн нэг өвчинд автаж байгаа юм нь энэ гутал шүү дээ. Ядахдаа шагайгаад ч юм уу, гэрийн товчийг нь ч юм уу өөрсдөө оёж авах хэмжээний юм байх ёстой байхгүй юу, бид нарт.

Тийм учраас аль болох ард түмэнд өгөөжтэй. Урд хөршөөс ч юм уу, эндээс тэндээс юм зөөхөөргүй, хил хаагдлаа гэхэд өөрсдөө амьдарч чадахаар хэдүүлээ тийм юм сэдье. Тэгэх үү.

**С.Ганбаатар:** С.Замира гишүүний асуултад Ж.Энхбаяр сайд хариулна. 5 номерын микрофонд.

**Ж.Энхбаяр:** С.Замира гишүүний асуултад хариулъя.

Бид нэг дүн шинжилгээ хийгээд судалгаагаа нэгтгэсэн. Сүүлийн 5 жил ер нь энэ салбар юу хийв гэж. Энэ олгосон зээлээр нийт

- ▶ 6694 үйлдвэрлэл үйл ажиллагаагаа өргөтгөсөн,
- ▶ 2252 жижиг үйлдвэр, цех шинээр ашиглалтад орсон,
- ▶ 8946 зээлдэгч хөнгөлөлттэй санхүүжилт авсан.

Ингэснээр 39 мянга 827 ажлын байр хадгалагдаж, 54 мянга 622 ажлын байр шинээр нэмэгдсэн.

Одоо энэ дээр харагдаж байгаа байх. Жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн тоо тасралтгүй өсөж байгаа.

Мөн их сонин үзүүлэлт гарсан. Жил бүр хамгийн багадаа 50 тэрбум төгрөгийн орлогыг татвар, нийгмийн даатгал, хүн амын орлогын татвараар энэ Жижиг, дунд үйлдвэрийн газар улсын төсөвт бүрдүүлж эхэлсэн байгаа. Байнга татвар төлөлт нь нэмэгдэж байна гэсэн үг.

Хамгийн гол нь эдийн засгаасаа илүү улс төр, нийгмийн маш том ач холбогдолтой. Хүн орон нутагтаа амар амгалан, тэндээ ажил хөдөлмөр эрхлээд орлоготой ажиллах тэр гол нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд энэ жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх бодлого үнэхээр том хөшүүрэг болдог юм билээ гэдгийг хэлэхийг хүсэж байна.

Ер нь өөдрөг байгаа. Нэмэгдээд л байгаа. Хүмүүс бүтээдэг, хийдэг, тарьдаг, ургуулдаг, хоршдог, хамтардаг л болоод байна. Одоо жоохон дахиад нэг шинэ түвшинд гаргах цаг ер нь болсон байх. 6 жил эх үүсвэр гаргаж өгсөнгүй. Яагаад гэвэл өмнө нь нэлээн үр ашиг, зарцуулалт, алдаа гарсан. Шүүмжлэлд өртсөн. Засан залруулах гэж нэлээн ажлууд хийгдлээ.

Тэгээд түрүүний хэлсэн үр дүнгүүд буюу ил тод, нээлттэй, хүртээмжтэй, олон үзүүлэлтээрээ хамгийн сайн үйлчилгээ явуулж байгаа төрийн байгууллагын хувьд 2 жил дараалан өндөр үр дүн үзүүлээд байж байна.

Тэгэхээр тэр төрөлжүүлэх буюу ялангуяа ахуйн үйлчилгээ үнэхээр тэг байгаа. Тэг дэмжлэгтэй байгаа. Одоо тэгээд ахуй үйлчилгээний соёлыг нэвтрүүлэх ажил дээр ялангуяа орон нутаг, сумдын түвшинд ахуй үйлчилгээний үйлчилгээ их сул байна. Үүнийг хүргэх хэрэгтэй байна.

**С.Ганбаатар:** Сайд хариуллаа. Ингээд М.Бадамсүрэн гишүүн асуулт асууя.

**М.Бадамсүрэн:** Жижиг, дунд үйлдвэрийн санг цэгцэлж байгаад баярлалаа.

Одоо цаашдаа Монгол Улсынхаа энэ давуу тал, боломж, бүс нутгуудын онцлог дээр тулгуурлаад ялангуяа уул уурхайн төсөл, экспортын баримжаатай энэ чиглэлээр ЖДҮ-гээ дэмжих хэрэгтэй байна.

Тэгээд жижиг, дунд үйлдвэрлэлээсээ гадна хамгийн гол нь нэгдүгээрт өрхийн үйлдвэрлэл. Хоёрт нь, бичил бизнесийг дэмжих чиглэлээр их томоохон бодлогыг хэрэгжүүлэх, улмаар энэ Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих тухай хуульдаа өөрчлөлт оруулах шаардлага байна гэж үзэж байгаа.

Тэгэхээр бичил, жижиг, дунд бизнесийн босгыг жоохон дээшлүүлмээр байгаа юм. Өөрөөр хэлбэл 1 тэрбум 500-г хамгийн багадаа 5 тэрбум гэдэг юм уу. Тэгэхгүй бол энэ хууль батлагдсан үеэс чинь хойш инфляц өөрчлөгдсөн, мөнгөний ханшийн хувьд асуудал байгаа. Тийм учраас үүнийг анхаарах хэрэгтэй байна.

Тэгээд ер нь жижиг дунд бизнесийг дэмжих төдийгүй өрх, бичил бизнесийг дэмжих гол хэдэн зүйл чинь

- ▶ Нэгдүгээрт, хөнгөлөлттэй зээл.
- ▶ Хоёрт нь, газар олголтыг үнэ төлбөргүйгээр давуу эрхээр олгох.
- ▶ Гуравдугаарт нь, дэд бүтцээр дэмждэг.

Ялангуяа эрчим хүч, тээвэр логистикийн хөгжил бизнес хөгжихөд хамгийн их саад болж байгаа учраас үүнийг бодлогынхоо түвшинд аваад, тэгээд технологи нэвтрүүлэх асуудал хамгийн чухал.

Ялангуяа энэ уул уурхайн том төслүүдэд энэ орон нутгийн жижиг, дунд бизнесийг дэмжихэд зориулж нээлттэй тендер зарладаг болох. Уул уурхайн компаниуд. Хэдий хувийн компани ч гэсэн энэ дээр хуулийн үйлчлэлд худалдан авах хуулийн үйлчлэлд хамруулж зарладаг байх нь орон нутгийн жижиг, дунд бизнесийг дэмжих нэг боломж. Тэгэхгүй бол орон нутаг, сум, аймаг чинь зах зээл нь хязгаарлагдмал. Ялангуяа сумын түвшинд маш бага учраас ингэж дэмжвэл зах зээлийг нь томруулах энэ боломж бүрэн бүрдэнэ гэж үзэж байгаа.

Тэгээд хөнгөлөлттэй зээлийг цаашдаа төсвөөс биш арилжааны банкны эх үүсвэрээр “Шинэ хоршоо”, “Цагаан алт”, “Хүнсний хувьсгал” хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлж байгаа төсөлтэй адилхан хүүгийн татаасыг дэмжих замаар явбал их чухал.

Сая танай гаргасан тайлан мэдээн дээр байна л даа. Ингээд 100 гаруй тэрбум төгрөгийн зээл олгоход 30 гаруй тэрбум төгрөг нь хувь хүний орлогын албан татвараар жишээлбэл орж байна. Тийм ээ. 20 гаруй тэрбум нь нийгмийн даатгалд орж байна.

Тэгэхээр энэ бол хэрвээ 500 тэрбум төгрөгийн зээл олгох юм бол үүнийг дахиад 150 тэрбум төгрөгийн татварын орлого олох нь байна шүү дээ.

Тэгэхээр энэ бол ингээд уялдаатай. Эдийн засаг бол ингэж хөрөнгө нь эргэлтэд орж байж өөрөө үр дүнгээ өгдөг. Танай мэдээлэл дээр хүсэлт нь 5 их наяд төгрөгийн хүсэлт ирсэн гэж байна шүү дээ. Хөнгөлөлттэй зээлийн. Гэтэл олгосон нь 1 тэрбум төгрөг.

Тэгэхээр 5 мянга дахин их хэмжээний эрэлт байна гэсэн үг. Өөрөөр хэлбэл олгож байгаа хэмжээнээсээ 5 мянга дахин их эрэлт байна гэдэг чинь энэ салбарт ямар их хэмжээний хөнгөлөлттэй зээлийн эх үүсвэр хэрэгтэй байна гэдэг нь тоо баримт, судалгаан дээр гарч ирж байгаа.

Манай Г.Лувсанжамц гишүүн байна. Барилгын жижиг, дунд компаниудад зээл олгодог практик бусад оронд байдаг гэдэг. Тэгвэл бид энэ дунд шатны мэргэжилтэй ажилтнуудад үр шим нь очдог болох. Зөвхөн том компани энэ зээлийг аваад.../минут дуусав/

**С.Ганбаатар:** М.Бадамсүрэн гишүүний асуултад хариулъя. 5 номер. Ж.Энхбаяр сайд.

**Ж.Энхбаяр:** Хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох зайлшгүй шаардлага үүсчихсэн байгаа.

Үнэхээр жижиг, дунд үйлдвэрлэл гэж юуг үзэх вэ гэдэг ойлголт нэлээн хуучирсан. Үүнийг зайлшгүй шинэчлэх ёстой. Одоо бид нарын нөгөө зээлийн босго хамгийн дээд хэмжээ 300 сая төгрөг байгаа. Үүнээс илүү байхгүй.

Арилжааны банкаар зээл олгоод тэр зээлийн хүүд нь өгчих юм бол манай байгаа эх үүсвэр нэг жил хийгээд л дуусаж байна буюу энэ агентлаг үйл ажиллагаа явуулахгүй зогсчихно. Ингээд өмнөх зээлээрээ эргэлдээд, орлогоо нөхөөд, өөрсдөө баяжуулаад өсгөөд ингээд яваад. 6 жил улсын төсөвгүйгээр өөрсөд өөрсдийгөө авч яваад, энэ үйл ажиллагаа, үзэсгэлэн худалдаа, гадаад сурталчилгаа юмнуудыг хийгээд байгаа нь энэ.

Юу хэрэгтэй байна гэвэл уг нь бодитой улсын төсвийн хөрөнгө оруулалтаар жижиг, дунд үйлдвэрлэлийг бойжуулах тийм инкубатор төвүүдийг бүсчилсэн маягаар нь бий болгох хэрэгтэй. Тэнд сургадаг, маркетинг ордог, бизнест зохиоход нь сургадаг, анхан шатын технологи эзэмшүүлдэг, заадаг. Ер нь ийм инкубатор төвүүдийг МСҮТ-өөр дамжуулаад МСҮТ-ийн дэргэд хийх үү, коллежуудын дэргэд хийх үү, эсвэл тусад нь хийх үү. Зайлшгүй нэг ийм дэмжлэг хийхгүй бол мөнгө өгснөөр та ингээд яв гэдэг байдал маань бас л нөгөө эрсдэлийг бүрэн хааж чадахгүй л байгаа.

Тэгэхээр ер нь нэлээн суралцуулах, тэр технологи дамжуулах ажлуудыг л хийх ийм зайлшгүй шаардлага байна даа.

**С.Ганбаатар:** М.Бадамсүрэн гишүүн тодруулъя.

**М.Бадамсүрэн:** Тэгэхээр хэд хэдэн бодлогын арга хэмжээ бас нэмж авмаар байгаа юм.

Батлан даалтын санг нэмэгдүүлмээр байна.

Зөвлөх үйлчилгээг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх хэрэгтэй байна. Төр хийхээс гадна.

Тэгээд ер нь зарчмын хувьд бол ингэмээр л байгаа юм. Нөхөн сэргээгддэггүй уул уурхайн том төслүүдээс олж байгаа орлогыг нөхөн сэргээгддэг салбар буюу энэ хөдөө аж ахуй, жижиг дунд бизнес, аялал жуулчлалын хүн бүрийн хийж чадах энэ бизнесийн салбарыг дэмжихэд л хөнгөлөлттэй зээлийн эх үүсвэр нэмэгдүүлэх. Үндэсний баялгийн сангийн хуульд юм уу, ямар нэгэн ийм санг л төсвөөс хараат бусаар бүрдүүлж өгөх хэрэгтэй. Бид нар. Тэгэх юм бол энэ ажил маань хөнгөхөн явна.

---

Дээр нь ингэж байгаа. Жижиг, дунд үйлдвэрлэл хөгжиж байгаа орнуудад дотоодын нийт бүтээгдэхүүний 40 хувийг жижиг, дунд бизнес эзэлдэг байхад Монголд ердөө 5.5 хувь байгаа байхгүй юу.

Тэгэхээр энэ бол ингээд энэ салбарт ямар их хэмжээний дэмжлэг хэрэгтэй байгаа, энэ салбарт ямар их хэмжээний төсөв зориулах, энэ баялгаас хөрөнгө хуваарилах хэрэгтэй байгааг харуулж байгаа л зүгээр л энгийн л тоон үзүүлэлт байгаа.

Тийм учраас энэ зүйл рүү бид онцгой анхаарч ер нь цаашдаа энэ дээр бодлого гаргаж, хөрөнгө илүү хуваарилах.../минут дуусав/

**С.Ганбаатар:** Санал хэлчихлээ. Энэ саналыг ажилдаа тусгаж ажиллуулаарай. Х.Жангабыл гишүүн асуулт асууя.

**Х.Жангабыл:** Та бүхэнд оройн мэндийг хүргэе. Ж.Энхбаяр сайддаа баярлалаа.

Баян-Өлгий аймгийн Булган сум гэж сум байгаа. Улаанбаатар хотоос хамгийн алслагдсан. Баян-Өлгийгөөс 300 километр газарт байрладаг. Дэд бүтэц хөгжөөгүй, зам байхгүй. Тэнд барааны үнэ Монгол Улсад хамгийн үнэтэй. Тэгээд их уулархаг газар байгаа юм.

Тэгээд Бүгд Найрамдах Хятад Ард Улстай хиллэдэг тийм онцлогтой.

Тэгээд ард иргэдийн маань аж амьдрал нь муудахаараа зэрэг л аймгийн төв, сумын төв рүү нүүгээд бараг дуусаж байна. Ер нь манай нутаг дэвсгэр, хил хязгаарын халдашгүй байдал ард иргэдтэй холбоотой шүү дээ. Ард иргэд л хамгаалдаг шүү дээ. Тухайлбал, энэ жил намар надад хүсэлт ирсэн. Уулархаг газартаа болохоороо тэжээл байхгүй. Мал оторлох. 20 мянган толгой мал Хөх сэрхийн нуруунд. Дархан цаазат газар оторлож байгаа. Тэр дархан цаазат газар зөвшөөрөл авах гээд нэлээд олон ажил болж байгаа. Байгаль орчин, уур амьсгалын сайддаа хүсэлт явуулаад нэлээд юм болж байж л 20 мянган мал өвөлжиж байна.

Тэгэхээр одоо би юу хэлэх гээд байна гэхээр малчдад малын тэжээл тарих бололцоогоор хангах ямар боломж байна. Энэ сангаас мөнгө, техник хэрэгсэл олгох боломж байна уу?

Ер нь Баян-Өлгий аймгийн Булган сум шиг л сумууд маш их байгаа л даа. Монгол Улсад. Яг тийм судалгаа байна уу? Яг тэнд тулж ажилладаг уу? Тэрний аргыг нь та нэг хэлээд өгөөч. Сайд аа, та. Тэгвэл мөн ч сайхан байна. Та тэр аргыг нь хэлж өгөхгүй бол ард иргэд маань асар их хүнд байдалтай байгаа. Ийм асуулт байна.

**С.Ганбаатар:** 5 номерын микрофонд Ж.Энхбаяр сайд хариулъя.

**Ж.Энхбаяр:** Ер нь Монгол Улсын нийт нүүдлийн мал аж ахуйд тулгарч байгаа гол бэрхшээл энэ.

Малын тоо хэт өссөнтэй холбоотойгоор бэлчээрийн даац 3-аас 8 дахин улс даяар хэтэрсэн. Бэлчээрийн даац хэтрээд ирэхээр идмэг сайтай ургамлын гарц эрс багассан. Мал бэлчээрээс авах ёстой шим тэжээлээ авч чадахаа больсон. Тарга тэвээргээ бүрэн авч чадахаа больсон.

Ингээд эрсдэлийг даван туулах чадавх буюу тэр нөөц нь хязгаарлагдмал. Үүнийгээ дагаад мал өөрөө давжаарч эхэлж байгаа их айхтар тоо гарч байна. Бог гэхэд 6-аас 8 килограммаар давжаараад, бод 30-аас 40 килограммаар давжаарч байгаа. Сүүлийн 30 жил. Бэлчээрийн дутагдалтай холбоотой.

Тэгэхээр зайлшгүй тэжээл. Тэжээлийг нь таримал, тэжээлийг нь нэмэлттэйгээр өвлийн цаг үеийг давахгүй бол дангаараа өөрөөрөө зүтгэх юм бол мал аж ахуй хэтэрхий их өндөр хохиролтой гарч байна. Өнгөрсөн жил 8.1 сая малыг бид үндсэндээ осгоод өлдөөгөөд хорогдуулж байгаа юм.

Тэгэхээр тэжээлийн баазуудыг бэлтгэх нь зайлшгүй. Тун удахгүй бид Засгийг газраар нийт Монгол Улсын хэмжээнд байгаа 1 сая га газар орчим га талбайд бид тэжээл ургамал, үр тариа тарьдаг, ногоо тарьдаг. Энэ газар маань Монголын хүн амыг 1.2-оос 1.3 сая орчим байх үеийн Атрын-I, II аяны хүрээнд эргэлтэд орсон. Одоо хүн ам 3.5 сая, мал сүрэг 70 сая хүрч байгаа ийм үед тэр шаардлагатай хэрэглээг хангахын тулд газраа нэмэх хэрэгтэй болж байгаа.

Бид 200 мянган га талбайгаар хөдөө аж ахуй эдэлбэрийн газрыг нэмэхээр газар тариалан, тэжээлийн тарималыг нэмэгдүүлэхээр Засгийн газраар оруулж хэлэлцүүлэхээр бэлдэж байгаа. Энэ бүх аймагт хамааралтай. Аймаг болгон газар нутагт тэжээл тарих талбайн нөөцөө судалгаа гаргаад Хүнс, хөдөө аж ахуйн яаманд нэгдсэн маягаар хүргүүлээрэй.

Тэгээд тэр 200 мянга дотор оруулаад бид ер нь Монгол Улс даяар тэжээлийн тарималыг эрс нэмэгдүүлэхгүй бол ийм хохирол байнгын автах болчихоод байгаа юм. Зайлшгүй нэмэлт тэжээл өвлийн улиралд, хаврын хохир цагт хэрэгтэй байгаа юм.

Тэгэхээр өөрөөсөө шийдэл нь тэжээл. Ингээд газрын асуудал ороод ирэхээр тэр газар таарсан зохион байгуулалттай, тэр хүчин чадалтай, ямар шаардлагатай тэжээл, үр бордоо хэрэгтэй вэ гэдэг нь өөрөө бодлого болоод үндсэн салбарынхаа бодлогод ороод хэрэгжээд яваад эхэлнэ.

Тэгэхээр Баян-Өлгий аймагт тэжээл тарих албан ёсны газар тариалангийн эргэлт бага байгаа болохоор тэнд хамрагдах нөгөө техникийн бодлого, үрийн бордооны бодлогод хамрагдахгүй болчихоод байгаа юм.

Тэгэхээр газраа тэлэх асуудлыг газрын чиглэлээр аймаг, сумууд иргэдийн хурлаараа албан ёсоор шийдэх ёстой. Шийдээд хүсэлтээ өгнө. Засгийн газар нэгтгээд атар газар эзэмших асуудлыг Засгийн газар шийддэг ийм зохицуулалттай явж байгаа.

Ахиад хэлье. Тэжээл. Тэжээл байж эрчимжсэн аж ахуй хөгжинө. Нүүдлийн мал аж ахуй маань эрсдэлгүй он давах, төлөө бүрэн авах, эдийн засаг ашигтай байх бололцоог л тэжээлийн гол суурь шийдэл нь тэжээл юм гэж.

**С.Ганбаатар:** Сайдын хариултыг сонслоо.

Би нэг юм тодруулахад. Тэр атар газар эзэмших талаар сум болон аймгийн иргэдийн Хурал, янз бүрийн холбогдох газрууд нэг шийдвэр гаргаж байж энэ явна.

Энэ шийдвэр гаргахад баахан хүнд суртлууд байдаг юм. Тэр чинь нэг ийм төлөвлөгөөнд оруулна. Газар зохион байгуулалтын төлөвлөгөөг батална. Эхлээд. Тэгээд төлөвлөгөө батлаад, тэгээд дуудлага худалдаа зарлагддаг ч билүү. Нэг тийм юм байгаа. Энэ дээр нэлээн хурдавчилсан маягтай, нэлээн тийм шуурхай явуулах арга замыг манай яамнаас яаж зохион байгуулж байгаа вэ? Түүн дээр Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооноос, Хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооноос хамтарсан тийм дэмжсэн гэдэг юм уу, шуурхайлсан тийм тогтоол шийдвэрүүдийг гаргах шаардлага байгаа юу? Энэ дээр сумдууддаа бид чиглэл өгөхөд та нарт тийм гарын авлага, материалуудыг энэ долоо хоногтоо багтааж бид авмаар байна. Энэ талаар та дэлгэрүүлж өгөөч.

**Ж.Энхбаяр:** Холбогдох материалыг бүрдүүлье.

Байнгын хорооноос Засгийн газарт чиглэл өгүүлбэл их сайн байна. Энэ ажлыг шуурхайл. Мал сүргийг эрсдэлээс хамгаалах тэр чадавхыг бий болгохын тулд бүс бүрт тэжээлийн баазуудыг бий болгох, тэжээл таримлуудыг нэмэгдүүлэх энэ чиглэлээр ажлыг хурдан шуурхай зохион байгуул гэсэн ийм үүрэг өгчихвөл бид “Атрын-IV” аян гэдэг тэр бодлогынхоо хүрээнд оруулаад явах гээд бэлдээд байгаа юм.

**С.Ганбаатар:** Энэ тун чухал. Ингээд Х.Жангабыл гишүүн тодруулж асууя.

**Х.Жангабыл:** Дарга та зөв юм хэллээ.

Малчид газар авах гээд жил явна. Тэгээд нэгдээд хоршоо бол нэлээд юм болно. Үүнийг хөнгөвчлөх тийм шийдэл өгчихвөл дарга аа, нэг сайхан бичээд. Тийм ээ. Тэгээд ер нь нэг суманд нэг юм уу, хоёр трактор аваад өгчхөд, Засаг даргын Тамгын газарт нь. Тэгээд өөрсдөө болгоод явчихдаг юм билээ. Тийм туршлагыг би харсан. Тийм техникээр хангаж өгвөл зүгээр байна.

**С.Ганбаатар:** 5 номер дээр Ж.Энхбаяр сайд тодруулж хариулна.

**Ж.Энхбаяр:** Нөгөө л төсвөө ярина шүү дээ.

Жижиг, дундын зээл 300 сая хүртэл дээд хэмжээ. Улсын төсвийн хөрөнгө оруулалт Ж.Энхбаяр сайдын эрх мэдэлд 5 тэрбум төгрөг л баталж өгсөн. Их Хурал. Би 1.6 тэрбумаар худаг гаргана. 1.8 тэрбумаар өөрийн харьяа бүх байгууллагуудынхаа засвар үйлчилгээг хийнэ. Жоохон тоног төхөөрөмжийг авна. Бас 1.6-гаар 30 хэдэн байгууллагынхаа үйл ажиллагааг чадавхжуулах ийм ажил хийнэ. Бусад бүх юм зээл, татаасны дэмжлэгт зарцуулж байгаа.

Нэг талаасаа яамны энэ жилийн онцлог бодлого тэр. Сайд төсөв батлуулчихаад өөрөө захиран зарцуулдгаас татгалзаж дандаа юм хийе, бүтээе, үйлдвэрлэе, тарья гэж байгаа улсуудад аль болох их хэмжээний зээл олгохын тулд тэр бүгдийг нь зээлийг нь татаасанд бодлогын дэмжлэг рүү хийчихсэн. Тэр нь арилжааны банкуудад зээл олгоод хөнгөлөлтийг нь манайхаас өгнө. Чи улаан буудай тариад.../минут дуусав/

**С.Ганбаатар:** Ж.Энхбаяр сайд нэмж хариулах уу? Болсон уу? Ж.Энхбаяр сайд нэмж тодруулж хариулъя. 5 номер.

**Ж.Энхбаяр:** Тэгэхээр Дархан хотод Байнгын хороо хүрч ирэхийг бид урьж байгаа. Тэр хүрээнд салбарын бүх дэлгэрэнгүй танилцуулгыг сайхан гишүүддээ танилцуулъя.

Тэгээд энэ хаврын чуулган болоход 2026 оны төсөв, мөнгөний бодлогын асуудал ярих үед төсөв, хөрөнгөтэй холбоотой юмыг жоохон хийгээд өгвөл хэрэгтэй л байна. Тэгэхээр үндсэндээ хийх ажил их. Миний эрх хэмжээ хязгаарлагдаад, санхүүгийн нөөц ийм бага.

Манайх Их Хурлаар баталчихсан 4 бодлого байгаа.

- ▷ “Цагаан алт”,
- ▷ “Хүнсний хувьсгал”,
- ▷ “Атрын-IV”,
- ▷ “Хоршоо”

Тэр бүх ажил оччихсон. Их Хурлаар хийх ажил нь бүр ингээд тодорхой төсөвтэй, хуультай болохоор ийм хүрээнд байгаа.

Тэгэхээр тэр бодлого дотроо жишээлбэл та газар олголтын асуудлыг аймгаасаа аймгийн иргэдийн Хурал шийдвэр гаргаад л, “Баян-Өлгий аймгийн хэмжээнд мянган га талбайд бид тэжээл тарина” гээд бодлого гаргаад Засагт өгчихвөл Засаг шийдээд өгчихнө шүү дээ.

Тэгээд тэр мянгаад.../минут дуусав/

**С.Ганбаатар:** Ж.Энхбаяр сайд дээр нэмж минут өгье.

**Ж.Энхбаяр:** Тийм.

Тэгэхээр харилцааны суурь нь газар. Баян-Өлгий аймаг мянган га талбай тэжээл тарина гэвэл мянган га талбайн техникийн бодлого, үрийн бодлого, хор бордоо, бусад бодлого нь дагаад ороод ирдэг.

Тэгэхээр газар байхгүй байхад танайд трактор өгөх шаардлага байхгүй гэж үзнэ. Нөгөө үр өгөх шаардлагагүй гэж үзээд байгаа байхгүй юу.

Тэгэхээр газрын харилцаагаа аймгийн иргэдийн Хурлаараа яаралтай шийдээд сум сум дээрээ нэгтгээд нэг дүнгээ гаргаад хурдан нийлүүлээч ээ гэж. Аймгууд түрүүчээсээ ирээд үндсэндээ дөхөж байна шүү. Аймгууд. Жишээлбэл, Сэлэнгэ аймаг гэхэд 50 мянган га талбайг шинээр нэмэхээр хүсэлтээ өгч байна. Дархан-Уул аймаг 5 мянган гаг нэмэхээр өгч байна. Аймгууд ингээд тоогоо өгөөд байна шүү.

Ингээд нийтдээ 200 мянга дотор хийгдээд л нэг ийм нийт эргэлтийнхээ талбайг 20 хувь нэмэгдүүлэх ийм тооцоо гарч хийгдэж байгаа ажил.

**С.Ганбаатар:** Сайдын хариултыг ойлголоо.

Энэ дээр би зүгээр тодруулж яамныхандаа, Ж.Энхбаяр сайдад хандаж хэлэхэд мэргэжлийн яам, мэргэжлийн шинжээч, экспертүүдтэй байгаа учраас аймгуудаас яг ямаршуу “Атрын-IV” аян ч гэдэг юм уу, “Цагаан алт”, тэр бусад зүйлүүд дээр ямар бүтээгдэхүүнээр дагнах вэ, ямар кластер хийх вэ, ямар атрын үйл ажиллагаа явуулах вэ гэдэг дээр мөнгөнөөс илүү чухал зүйл гэвэл мөнгө байгаа тохиолдолд яаж хэрэгжүүлэх вэ, ямар үр, ямар сорт, ямар тракторын шинж чанар, ямар ажлын зохион байгуулалт, хүний нөөцийн бодлого барих вэ гэдэг энэ тооцоо судалгаа, шинжээчийн дүгнэлтүүд. Энэ талаар Та нараас гарчихсан зүйлүүд байгаа байх гэж бодож байна.

Тэгээд энэ зүйлүүдийг л бидэнд, энэ аймгуудад, энэ бүх гишүүдэд Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны зүгээс авахыг хүсэж байгаа. Яаралтай авна. Аваад гишүүдэд өгсний дараа аймгуудад энэ чиглэлээр яаралтай ажиллах шаардлагатай.

Хөдөө аж ахуйн бодлого бол бид бодлогын яамандаа удирдуулна. Аймаг болгон юм уу, сум болгон юм уу, баг болгон дур дураараа газар эзэмших гээд давхина гэж байхгүй.

Энэ утгаар нь би тодруулж, яг энэ талын бодлогоор тэр судалгаа хийсэн зүйлүүд, чиглэлүүд бидэнд их хэрэгтэй гэдгийг энд нэмж хэлэхийг хүсэж байна.

Ингээд Г.Очирбат гишүүн асуулт асууна.

**Г.Очирбат:** Оройн мэнд хүргэе.

Манай аж үйлдвэржилтийн бодлого Монгол Улсын бодлого ер нь их тийм түвэгтэй байдал руу орчихсон. Нэг хэсэг нь жижиг, дунд үйлдвэрлэл гээд энэ Хүнс, хөдөө аж ахуйн яам руугаа явчихсан байдаг.

Нөгөөдөх нь Эрдэс баялгийн яам руу оччихсон. Тэгээд аж үйлдвэрийн бодлогын том бичиг баримт байдаггүй. Энэ дээр яам ямар судалгаа хийсэн юм бэ? Одоо жишээ нь танай яам.

2012-2016 онд Ардчилсан намынхан аж үйлдвэрийн тусдаа яамтай болгосон шүү дээ. Тэгээд яамтай болгоод яг Монгол Улсын хөгжил, нөгөө баялаг бүтээх салбар ингэж хөгжих юм гэсэн ийм цогц бичиг баримтыг бас тухайн үед гаргаж байсан. Яг одоо ямар юм мөрдөж байна. Нэгд.

Хоёрт нь, түрүүн Байнгын хорооны дарга ч хэлээд байна. Монгол Улсын бүсчилсэн хөгжил гэж яриад байгаа.

Тэгээд яг аль аймгийн нөөц аль үйлдвэрийн салбарыг хөгжүүлэхэд боломжтой юм бэ гэсэн ийм судалгаанууд байна уу? Энэ судалгааны бичиг баримтууд бид нарт хэрэгтэй байгаа юм. Энэ дээр хариулт авчихъя.

Гуравдугаарт, түрүүн тараасан материалтай танилцаад сууж байна. Энэ дээр чанаргүй зээлийн 79 хувьтай байхыг бид 39 хувь хүртэл бууруулсан гээд тайлангаа өгчхөж. Тэгээд 39 хувь чанаргүй байна гэдэг чинь Жижиг, дунд үйлдвэрлэлийн сангаар гараад байгаа зээлүүд чинь ерөөсөө л тэр хэн нэгэн дарга, эрх мэдэлтнүүдийн хармаагаар ороод л дуусчихсан юм биш үү.

Тэгэхээр энэ дээр яам яг тодорхой бодлого бариад. Бид энэ зээлийнхээ эргэн төлөлтийг 5 хувьд бариулна ч гэдэг юм уу, тодорхой явахгүй бол урьд

урьдын бид гашуун туршлага байгаа шүү дээ. Тийм ээ. Их Хурлын гишүүд нь 950 сая төгрөгийг хуваагаад авчихсан гашуун туршлага байгаа.

Тэгэхээр энэ дээрээ нэлээн тийм тодорхой тоон үр дүнд хүрэх зорилт тавиад ажиллах юм бол цаашдаа дараа нь дахиад энэ сангаас зээл авч байгаа хүмүүс чинь илүү хариуцлагатай болж, илүү тэр зээлээ эргэн төлдөг ийм механизм руугаа орох юм биш үү. Тэгээд ийм гурван асуулт асуучихъя. Тэгээд тодруулъя.

**С.Ганбаатар:** Ж.Энхбаяр сайд хариулъя. 5 номерын микрофоныг нээж өгье.

**Ж.Энхбаяр:** Бодлогын тухайд үнэхээр нэгдсэн хууль эрх зүйн орчин, бодлого дутмаг байгаа.

Бид зүгээр суугаагүй. Энэ хөнгөн хүнсний үйлдвэрлэлийн талаар баримтлах төрийн бодлого, Хөнгөн хүнсний үйлдвэрлэлийн тухай хуулийн төслийг бэлдээд дууссан.

Үүнийгээ хүсвэл ажлын хэсэг гаргаад Байнгын хорооныхоо гишүүдэд өгч болно. Гишүүдээр өргөн барьж болно. Яам өргөн барих хувилбар, аль ч хувилбарт бид нээлттэй хамтран ажиллана.

Ер нь Худалдааны хууль, Хөнгөн хүнсний үйлдвэрийн тухай хууль, хөдөө аж ахуйн салбарын бодлогын нэлээн олон хуулиудыг бэлдээд дууссан байгаа.

Тэгэхээр энэ дээр гишүүд санаачилгатай байвал бид хамтарч ажиллана.

Хөнгөн хүнсний үйлдвэрлэл, жижиг, дунд үйлдвэрлэл манай яаман дээр. Хүнд буюу уул уурхайн үйлдвэрлэл Уул уурхайн яаман дээр бодлого нь төвлөрч байгаа.

Ер нь цаашдаа Үйлдвэр технологийн паркийн хууль гарсантай холбогдуулан төрөлжүүлэн хөгжүүлнэ гэдгээрээ паркийн системээр хөгжүүлнэ гэдэг бодлого гарчихсан. Тэр хүрээнд Та бүгдийг очиход хэчнээн, хаана ямар паркт ажил явагдаж байхаар танилцуулгад бэлдэж байгаа.

Тэгээд бодлогын буюу судалгааны юмнууд нэлээн хийгдсэн. Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал, Монгол Улсыг хөгжүүлэх “Алсын хараа-2050” хөтөлбөрийн хүрээнд ер нь аймаг, сум болгоны давуу тал, сул талыг бүгдийг нь тооцоод таталдсаны хүч, тооцоог нь гаргаад эдийн засаг, эрдэс баялгийн нөөц, түүхий эдийн нөөц бололцоог нь гаргаад ямар ямар чиглэлийг онцгойлон анхаарах вэ гэдэг нь бүр нэлээн гарчихсан байгаа.

Тэгэхээр тэндээс бид ер нь гол хөдөө аж ахуйтай холбоотой материалуудыг бэлдээд гишүүдэд манай яамтай танилцах үйл ажиллагааны үед өгье.

Тэгээд энэ Жижиг, дунд үйлдвэрийн агентлаг байгуулсан түүх маань энэ. Үнэхээр зээлийн зарцуулалт замбараагүй, бодлогогүй. Ялангуяа 2012-2016 оны үед нэлээн их том зээлүүд гарсан. Нөгөө талаас бас их улстөржилт явсан. Орон нутгаас хүсэлт их ирсэн. Гишүүд маань өөрсдөө бичиг хийгээд манай орон нутгаас ирсэн энэ зээлийг дэмжиж өгнө үү гээд бичиг байх өгсөн.

Тэр хүрээнд баахан улс, Их Хурлын бараг гишүүд бүгд энэ зээлийг олоход нөлөөлсөн маягаар улс төр болж улс төрд ашиглагдсан. Ингээд хууль хүчний байгууллага ажлаа дууссан. Үндсэндээ гэм буруутай шалгасан, тогтоосон юмнууд нь бас яг эцсийн дүндээ маруухан шүү дээ. Нэг, хоёр хүний ажлын хариуцлага тооцогдоод л өнгөрч байгаа юм. Түүнээс үүнийг аваад идээд алга болчихсон зүйл байхгүй.

Ингээд агентлаг бий болсон. Энэ бүх олон ийм багцуудыг хүлээж авсан. Олон газрын. Тэр олон чанаргүй багцуудыг хүлээж аваад тусгай актив газраа байгуулаад ингээд хүч тавиад хөөцөлдсөөр байгаад далан хэдэн хувийн чанаргүй байсан зүйлийг чинь л гучин хэд рүү оруулаад ирж байгаа байхгүй юу. Одоо үүнийгээ нэлээн цаашид нь улам үргэлжлүүлэх.

Түрүүн хэлсэн 1993 оноос хойш бүх салбарт явсан бүх зээлүүд бүгдийг нь базаад энэ агентлаг дээр нийлүүлсэн юм.

Тэгээд үүнийг л зээлийн барагдуулалт хийгдээд л, явагдаад л овоо ахицтай, ил тод. Ер нь далан хэдэн хувийн найдваргүй зээлийг гучин хэд болтол нь энэ богино хугацаанд ер нь их боломжийн ажлаад нэлээн гаргаад. Тэгээд улсын төсвөөс ямар ч төсөвгүйгээр дандаа өөрийн орлогоороо явдаг болчихсон шүү дээ. Тийм учиртай юм шүү. Зохион байгуулалтын хувьд нэлээн өөрчлөлт хийгээд явж байгаа ажил. Хариулж дууслаа.

**С.Ганбаатар:** Ж.Энхбаяр сайд хариуллаа. Ингээд Б.Пунсалмаа гишүүн асуулт асууя.

**Б.Пунсалмаа:** Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе.

Жижиг, дунд үйлдвэрлэл гэдэг бол эдийн засгийн суурь. Энэ бол уул уурхайгаас шал өөр. Уул уурхай бол байгалийн шавхагддаг нөөц. Байгалийн нөөц шавхагдана. Үнэ ханш тогтворгүй. Эдийн засгийг тогтворгүй болгодог.

Жижиг, дунд үйлдвэрлэл гэдэг өөрөө хэдий хэмжээний бүтээгдэхүүн үйлдвэрлэнэ тэдий хэмжээгээр нь үнэ ханш нь буурч байдаг, эдийн засгийг тогтворжуулалтыг авчирч байдаг ийм зүйл.

Тийм ч учраас улс орнууд нийт эдийн засгийнхаа бараг 60 гаруй хувийг жижиг, дунд үйлдвэрлэл дээр байршуулж байгаа.

Гэтэл манай Монгол Улсад энэ тоо 20 хувь дээр байна. Бас нэг тоо. Ер нь сонирхуулаад хэлчихэд Топ-100 аж ахуйн нэгж нь өнөөдрийн дотоодын нийт бүтээгдэхүүнийхээ 83 хувийг бүрдүүлж байгаа юм шүү. Ихэвчлэн уул уурхайн компаниуд.

Тэгэхээр цаана нь 200 гаруй мянган аж ахуйн нэгжүүд жижиг, дунд үйлдвэрлэл дээр зээл хүлээгээд, зээл дэмжлэг тусламж байвал хийе бүтээе гээд хүлээгээд байж байна.

Ийм нөхцөл байдал дээр Жижиг, дунд үйлдвэрлэлийн сан тогтвортой байнга ажиллаж байгаа. Гэтэл жилдээ өгч байгаа зээл нь 287 төсөл дээр л жил болгон дунджаар өгсөн байна. Жишээлбэл, 2023 онд 287 төсөл дээр, 2022 онд 267 төсөл дээр. Энэ бол 200 гаруй мянган аж ахуйн нэгжүүд хүлээж байгаа цаг хугацаанд маш хангалтгүй, маш цөөхөн аж ахуйн нэгжүүдийн төслүүдэд зээл өгөгдөж байна гэсэн үг.

Тэгэхээр үүний цаана Зээлийн батлан даалтын сан яаж ажиллаж байна аа? Энэ 200-аад мянган компаниуд, хүлээгдэж байгаа компаниудад энэ жижиг, дундын зээлийг хүргэх өөр ямар боломж байна? Нэгдүгээрт.

Хоёрдугаарт, зээл авсан компаниуд ч гэсэн тендерт ороод төрийн дэмжлэгээр төрийн ханган нийлүүлэгч компаниар оролцох боломжтой байна. Хуульдаа “үндэсний дотоодын компаниудыг дэмжинэ” гээд орж ирсэн байгаа.

Гэтэл Тендерийн тухай хууль дээр “хямд үнэ” гэдэг нэг тээгтэй. Дээрээс нь хямд үнээс гадна “багцаар бараа, бүтээгдэхүүн авна” гээд бас нэг чагт тавьчихсан сууж байгаа.

Энэ төрийн худалдан авалт, энэ хоёр тээг, хаалтыг авч хаях, үндэсний худалдан авагч нарыг тэргүүн эгнээнд төрийн тендерийн худалдан авалтаар оруулдаг болгох ийм ямар боломж бололцоо байна вэ? Хоёр асуултыг асууя. Баярлалаа.

**С.Ганбаатар:** Б.Пунсалмаа гишүүний асуултад Ж.Энхбаяр сайд хариулъя. 5 номерын микрофоныг нээж өгье.

**Ж.Энхбаяр:** Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа, үйлчилгээ худалдан авах хуульд яг таны хэлсэн заалтууд, чагтууд байгаа. Нэг талдаа бололцоотой. Нөгөө талдаа боломжгүй.

Тэгэхээр заавал бодлогын хувьд дэмжих. Нөгөө яриад байгаа жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх хууль эрх зүйн орчинг ахиад шинэчлэхгүй бол үнэхээр цаг үеэс хоцорчихсон.

Тэгэхээр манай харьяалах Байнгын хорооны гишүүд яг энэ дээр ажиллахад. Бид үндсэндээ хуулийн төслийг бэлдээд дуусчихсан. Нэлээн боловсруулалт нь хийгдчихсэн. Нийгмийн шаардлага, үндэслэл их сайтай, нийгмийн том дэмжлэг авах бололцоотой ийм хуулийн төсөл бэлэн байгаа.

Үүнд ажлын хэсэг гаргаад энэ хүрээнд аваад хамтраад явахад бэлэн байна.

Жилдээ 260, 270 аж ахуйн нэгжид жижиг, дунд бизнес эрхлэгч зээл олгож байна гэдэг маань манай нийт жижиг, дунд үйлдвэрлэлийн салбарын 0.1, 2 хувь. Их өндрөөр бодоход 0.2-хон хувьд нь л хүрч байгаа юм.

Цаана нь 99.8 хувь хоосон. Биш ээ. 99.09 хувь нь юм уу, 99.08 хувь нь байгаа юм. Хүрэхгүй. Үнэхээр хүртээмжгүй, хүрэлцээгүй, маш бага.

Хамгийн сайн зээлээ төлдөг, хамгийн шударга, хамгийн хэл амгүй ажлаа хийж байгаа, орон нутагт ажлын байрыг бий болгож байгаа нь жижиг, дунд үйлдвэрийн салбар яваад байгаа юм.

Тэгэхээр бодлогын хувьд, эх үүсвэрийн хувьд, эрх зүйн хувьд сайн дэмжээд өгөх ажлыг манай Байнгын хороо маань санаачилаасай. Яам бол бүх шаардлагатай мэдээллээр хангаад хамтраад явахад бэлэн байна л гэж хэлье дээ. Баярлалаа.

Нэг үеэ бодвол улсууд өөр болчихсон. Манайх хийдэг, бүтээдэг, тарьдаг, ургуулдаг, санаачилдаг, гадаад дотоод яваад юмны хандах хандлага үнэхээр өөрчлөгдчихсөн. Гадаадад олон залуучууд жижиг, дунд үйлдвэрлэл дээр ажилласан, ноу хау эзэмшсэн, хөөрхөн шинэ санаанууд аягүй их олноор байна. Олон зуугаараа байна. Тийм. Одоо цаг нь болсон.

**С.Ганбаатар:** Б.Пунсалмаа гишүүн тодруулж асууя.

**Б.Пунсалмаа:** Нэг зүйл тодруулж асуухад 200-аад мянган аж ахуйн нэгжүүд хүлээгдэж байгаа үндсэн шалтгаан нь зээлийн барьцаа хөрөнгө хүрэлцэхгүй байгаатай холбогдож байгаа.

Тэгэхээр энэ дээр Зээлийн батлан даалтын сан энэ асуудлыг шийдэхийн тулд байгуулагдсан гэж ойлгож байгаа. Зээлийн батлан даалтын сан маань өнөөдөр ер нь хэдэн компанид батлан даалт гаргаж байна вэ? Үүнийг нэмэгдүүлэх ямар боломж байна вэ? Хэрвээ боломж нөхцөл бүрддэг юм бол жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих банк байгуулбал ямар вэ. Тийм ээ. Энэ банк нь өөрөө зээлээ өгдөг, өөрөө компаниудаа чадавхжуулдаг, инкибатар бүрдүүлдэг, өөрөө зээлээ судалдаг, тэгээд хариуцлагаа хүлээдэг, эдийн засгаа томруулдаг ийм нэлээн томоохон, дараачийн шинэ түвшинд хүргэх ёстой гэдэг шийдэл их зөв.

Тэгэхээр энэ дээр бид нэлээн өөрчлөлт хийх ёстой юм байна. Та энэ Батлан даалтын сан дээр нэг санал хэлэх үү?

**С.Ганбаатар:** Ж.Энхбаяр сайд. 5 номерын микрофон.

**Ж.Энхбаяр:** Нэг ийм зүйл бас үүсээд байгаа. Зээлийн батлан даалтын сан зөвхөн арилжааны банкаар дамжиж олгосон зээл дээр батлан даалт хийж байгаа. Энэ жижиг, дунд дээр өгөхгүй. Тэр хууль, дүрэм журам нь бас болохгүй байна гэж.

Тэгэхээр үүнийг бас тэр өөрчлөлтийн хүрээнд хийх.

Нөгөө талаасаа 300 хүртэл сая төгрөг олгож байгаа болохоор барьцаа хөрөнгөний шаардлага гайгүй. Хөрөнгийн дутагдал нь л гол байна. Түүнээс биш улсууд 300 сая төгрөгийн барьцаанд унах унаа, орох орон, энээ тэр үйл ажиллагаагаа тавьчихвал ер нь бараг гарчхаж байгаа юм. Гол нь мөнгө, эх үүсвэрийн дутагдал. Гол асуудал нь ердөө л 99 хувь нь тэр.

**С.Ганбаатар:** Г.Лувсанжамц гишүүн асуулт асууна.

**Г.Лувсанжамц:** Сайд сая хэлж байна. Өнгөрсөн алдаа дутагдлаасаа суралцаад чанаргүй зээлийг нь бас 30 хувь орчим хүртэл багасгаж чадсан байна. Энэ дээр нэлээн сайн хүчин чар чармайлт гаргаад үр дүнд хүрч байна гэж харлаа. Цаашдаа бас бүр багасгаад явах тал дээр ингээд хичээгээд ажиллана гэж байна. Итгэл найдвар төрж байна.

Ер нь манай энэ төрийн бодлого, зорилгууд нэг зүйл рүү чиглэх хэрэгтэй байгаад байгаа юм. Хаашаа вэ гэхээр зорилтот бүлэг буюу залуусыг ажлын байртай болгох, орлоготой болгох, тогтвортой ажиллах орчныг нь бүрдүүлж өгөх ёстой байгаа юм.

Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих энэ сан зорилтот бүлгээ тодорхойлж байгаад жишээлбэл нийт зээлийн 50 хувийг нь 40-өөс доош насны, эсвэл 35-аас доош насны “старт ап” буюу “гарааны бизнес” эрхэлж байгаа залууст олгоно.

Гадаадад амьдарч байгаа монгол залуучууд эх орондоо эргэж ирээд бизнес эхлүүлэхэд нь зээл олгоно. Эсрэгээрээ хотод амьдарч байгаа залуучууд төрсөн нутагтаа, эсвэл өөр орон нутагт очоод бизнес эхлүүлэх гэж байгаа бол зээл олгоно гэх мэтээр зорилтот бүлгээ маш сайн тодорхойлж өгөх хэрэгтэй байгаа юм. Ингэснээрээ бид залуу үе гадагшаа дайжихгүй, гадагшаа дайжсан буцаж ирээд ажиллах хүчний хомсдолтой байгаа энэ зах зээл маань залуучууд эргэж ирснээрээ сэргээд, эдийн засагт эзлэх хувь хэмжээ нь нэмэгдээд, иргэдийн итгэл дээшилнэ гэж бодож байгаа.

Та бүхний 2020-2024 оны ажлын тайланг харлаа. Нийт олгосон зээл, авсан татвар. Үүнийгээ нэг ажлын байрыг хэдэн төгрөгөөр бий болгож байгаа вэ гэсэн шалгуур үзүүлэлт буюу Кэй Пи Ай гаргаж өгөөд төсвийн 1 дүгээр хавсралт дээр тусгамаар байна.

Одоо сая тооцож үзлээ. Нэг ажлын байрыг 7 сая төгрөгөөр буюу 2000 доллар байхад л Монгол залуучууд ажлын байртай болоод байгаа байхгүй юу. Энэ бол маш сайн тоо. Цаашдаа үүнийгээ багасгаад 1500, 1000 мянга гээд багасгаад явах тийм зорилтуудаа тавих хэрэгтэй.

Нэг асуулт байна. Гадаадад борлуулалтын цэг байгуулсан гэж байна. 3 газар байна. Жилдээ 17.1 тэрбум төгрөг борлуулсан гэж байна. Энэ 3 цэгийг ажиллуулахын тулд хэдэн төгрөг зарцуулж байгаа вэ? Шалгуур үзүүлэлт буюу үр дүнг нь л асууж байгаа тийм асуулт байна. Америк, Герман, Хятадад 3 дэлгүүр байна. Нийт 17.1 тэрбум борлуулалт хийсэн байна. Үйл ажиллагааны зардалд хэдийг зарцуулсан бэ?

Хоёр дахь асуулт. Өмнө нь бизнесийн зээл олгож байгаа компаниудын хөрөнгө оруулалтын өгөөж, хөрөнгийн өгөөж буюу return on investment<sup>1</sup>, return on equity<sup>2</sup>. Энэ ямар хэмжээтэй байгаа вэ? Тийм судалгаа хийж байгаа юу?

**С.Ганбаатар:** Гишүүний асуултад Ж.Энхбаяр сайд хариулъя. 5 номерын микрофон.

**Ж.Энхбаяр:** Нэг ажлын байр бий болгох, нэг ажлын байр хадгалахад бид шинжилгээ хийж үзсэн. 15 сая төгрөгийн өртөгтэй бий болж байгаа. 15 сая төгрөг.

Худалдаа төвлөрсөн 3 цагт Made in Mongolia буюу манай дотоодын энэ үйлдвэрлэлийн барааг нэгтгэж олон хамтарч нэгдсэн борлуулалт хийдэг ийм 3 цэгийг авахад нь бид бодлогын хувьд дэмжлэг үзүүлж яриа хэлэлцээрийг нь хийж тэр газрыг нь авч өгч байгаа. Бас ингээд улсыг төлөөлөөд, манай ийм

<sup>1</sup> Хөрөнгө оруулалтын өгөөж (ROI) нь хөрөнгө оруулалтын ашигт ажиллагаа, оролцооны хэмжүүр үзүүлэлт.

<sup>2</sup> Өмчийн өгөөж (ROE) нь бизнес эрхлэгчид өөрийн хөрөнгөөс хэр үр ашиг олж байгааг харуулдаг санхүүгийн харьцааны үзүүлэлт.

бодлого явж байгаа, дэмжээд өгөхөөр тэнд нөгөө сайн санаат хандивлагч нар, янз янзын яриа хэлэлцээрээр 3 том цэгийг нь аваад өгсөн.

Одоо жишээлбэл тэр Нью-Йоркийн дэлхийн худалдааны төв дотор байгаа дэлгүүрт гэхэд манай 20 гаруй аж ахуйн нэгжүүд эндээс бараагаа нийлүүлээд каргонд хийж явуулаад, тэнд нэг монгол компани төлөөлөгч нь тосож аваад бүх 20 компанийнхаа юмыг нийлүүлээд борлуулах маягаар гэдэг юм уу, ийм маягийн эхний ажил явж байна.

Үүнийгээ бид цаашдаа нэлээн олон газар нэмж өгье. Гол нь бид тэнд мөнгө зарж чадахгүй байгаа. Нэг төгрөг ч зараагүй байна. Бид зүгээр яриа хэлээр хийгээд бас ингээд дэмжээч туслаач, ийм төвүүдийг хийе, Монголын барааг гаргая. Тэгэхгүй нэг анхан шатын хөөрхөн хөөрхөн брэндүүд дангаараа гарахаар тэр том зүйл дээр дийлэхгүй байгаа байхгүй юу.

Тэгэхээр бид тэр хамтран ажиллах бололцоог нь гаргаад нэг гэрээг нь хийж өгөөд нэлээн хугацаатай хөнгөлөлттэй зээл, түрээсийг нь хийгээд өгчхөж байгаа юм. Зарим нь түрээсгүйгээр ингээд аваад өгчхөж байгаа юм. Энэ нь тэгээд тодорхой хугацаанд нийлээд нэг ийм хөөрхөн бизнесийн модель болоод идэвхтэй яваад байна л даа. Аж ахуйн нэгжүүд бүх зардлаа, тэнд худалдагчийнхаа зардлаас авхуулаад тээврийн зардлаа хуваагаад эхлэхээр бас тун эвтэйхэн буюу гадаад зах зээл гарах тийм маягийн идэвхжүүлэлт.

Үзэсгэлэн худалдаануудыг нэлээн хэдэн гол гол газруудад сайн зохион байгуулж, нэлээн сайн. Ялангуяа Бүгд Найрамдах Хятад Ард Улсад хийж байгаа манай үзэсгэлэн худалдаанууд, экспонууд амжилттай ер нь сайн том борлуулалт хийдэг, захиалгууд авдаг, их үр дүнтэй ийм ажлууд бас хийгдэж байгаа.

Тэр хөрөнгийн өгөөжийн талаар тэр судалгаануудыг гаргаад өгье. Ямар ч байсан ажлын байрыг бид ер нь ямар зардал гаргаад ажлын байр бий болгоод байгаа юм бэ гэхэд 15 сая л гарч байна. Зээл. Тэгээд авсан зээлээ хэрхэн ашиглаж байгаа талаасаа харахад нөгөө зээлийн эргэн төлөлтөөр л анзаарагдаад байгаа юм. Ер нь ашиглалт их сайтай, эргэн төлөлт их сайтай. Нэг үеэ бодвол юм их хийдэг бүтээдэг, хүмүүс их хариуцлагатай болоод байгаа ийм дүр зураг харагдаж байна даа.

Нэг ийм сонин зүйл. “Хотоос хөдөөг зорьё” гэдэг ийм залуусын бүлэгтэй уулзлаа. Хотоос хөдөөг зорьцгооё гэж энэ. Энэ Америк, Герман, Япон, Солонгост ажиллаж байгаад ирсэн залуучууд дандаа тийм жижиг, дунд үйлдвэрлэл, хөдөө фарм дээр ажилласан залуучууд тэр хэв маягийг орон нутагт бий болгохоор хамтраад, зохион байгуулалтад ороод ажиллаж байгаа.

Жишээ нь, Солонгос Улсад 14 жил ажиллаад 500 сая төгрөгтэй ирсний охин байгаа. Одоо 70 үнээтэй болчихсон. Жилийн орлого нь 800 сая болчихсон. Тэгээд яг Солонгост нэг үнээнээс авдаг ашиг шимийг Монголд яг авдаг болж байгаа. Яг тэр стандартыг сурчихсан байгаа юм. Яг тэжээл, нормыг яг. Тэр стандартаар өгөөд түүгээр нь тэжээгээд ирэхээр Монголд мөн адилхан тийм өндөр өгөөж өгч байгаа гэдэг юм уу, нэг ийм хөөрхөн хөөрхөн жишээнүүд олон байна.

Тэгэхээр би одоо ийм зүйл бодогдоод байгаа юм. Байнгын хороотойгоо зөвшилцөөд бүгдээрээ санал нийлбэл энэ “Хотоос хөдөөг зорьё” гэж байгаа, хөдөө амьдаръя, шинэ амьдралын хэв маягийг бий болгоё гэж байгаа. Нөгөө талдаа төвлөрлийг сааруулах, түгжрэлийг бууруулах олон бодлогод нийцсэн ийм залуучуудын хөдөлгөөнийг дэмжиж, тэд нар луу орон нутагт ажиллах, бизнес эрхлэх бололцоог нь дэмжих зээл өгмөөр байна. Нөгөө талаар кластеруудыг босгож ирмээр байна. Сүүний, хүүхдийн тэжээлийн, ногооны гэдэг юм уу гээд. Олуулаа тариад дундаа нэг бүтээгдэхүүн хийдэг гэсэн ийм маягаар. Би одоо байгаа эх үүсвэр дээрээ тэгээд.../минут дуусав/

**С.Ганбаатар:** Г.Лүвсанжамц гишүүн тодруулж асууя.

**Г.Лувсанжамц:** Баярлалаа. Их тодорхой хариултууд өгч байна. Сая нэг ажлын байрыг хадгалах дээр сая та 15 сая төгрөг гэж байна. Үүнээсээ үр дүнгээ тооцох буюу нийгмийн даатгал, НӨАТ төлснийгөө хасаж байгаад яг чанартай шалгуур үзүүлдэг Кей Пи Ай-г нь тавьж өгөх ёстой гэж тийм санал байгаа.

Тодруулж асуух зүйл байгаа нь гадаадад байгаа энэ 3 дэлгүүр дээр та бас нэг ч төгрөг зараагүй гэж байна шүү дээ. Тийм ээ. Энэ маш сайн байгаа юм.

2025 онд хэрэгжүүлэх ажил дээр нь “бизнес инкубатор төв” барьж байгуулна. Орон нутагт “ахуйн үйлчилгээний цэг”-ийг байгуулна гэж байгаа. Энэ дээр бас мөнгө зарах гээд байна уу? Ухаалаг аппликэйшн хөгжүүлнэ гэж байна. Энэ дэмий болов уу гэж бодож байна. Нэгэнт бид e-mongolia байгаа юм чинь e-mongolia руугаа гадаадад байгаа залуучууд ч гэсэн харчих боломжтой. Энэ дээрээ нэгтгээд хөгжүүлэлт хийгээд явчихсан нь хямд бөгөөд хүртээмж сайтай юм болов уу гэсэн.

**С.Ганбаатар:** 5 номерын микрофоныг нээж өгье. Ж.Энхбаяр сайд хариулна.

**Ж.Энхбаяр:** Тэгээд бид олон улсын байгууллагууд, төсөл хөтөлбөрт л хандаж байгаа байдал маань энэ. Байгаа эх үүсвэр маань. Би түрүүн хэлсэн 5 тэрбумын л хөрөнгө оруулалт байгаа. Өөр юм хийх бололцоогүй.

Тэгэхээр бид бусад олон улсын байгууллага зээл, тэр тусламжийн чиглэлээр л санал, санаачилга тавиад төслөө боловсруулаад л, хөөцөлдөөд л, уулзаад л нэг ийм зүйл хийе бойжуулах төв байгуулъя гээд. Тийм идея санаа гаргаад л хөөцөлдөж байгаад л, тэр ажлаа л зорилт болгоод тавьж байгаа юм гэж.

**Г.Лувсанжамц.** Оройн мэнд хүргэе.

Таны тэр мэдээллийн систем дээр ойлголоо. Үүнийгээ хэрхэн хөгжүүлэх вэ гэдэг юман дээрээ байгаа нөөцийг сайн зөв ашиглаад л явчих юм.

**С.Ганбаатар:** П.Ганзориг гишүүн асуултаа асууя.

**П.Ганзориг:** Энэ жижиг, дунд үйлдвэрлэл, бизнесийг дэмжих асуудал маш чухал асуудал. Үүнийг өнгөрсөн намар 2025 оны төсөв хэлэлцэх үеэр ч гэсэн би гишүүний хувьд төсөв мөнгийг нь нэмэгдүүлэх тал дээр саналаа илэрхийлж байсан.

Ер нь хөгжиж байгаа улс орнуудын хувьд, ялангуяа ажлын байрыг чинь бий болгодог гол хэсэг нь жижиг, дунд бизнесүүд, үйлдвэрүүд байдаг.

Ер нь жижиг дунд бизнес үйлдвэрүүдийн ч гэсэн үндсэн номер нэг гол зүйл нь ажлын байр шүү дээ. Ард иргэд ажилтай байж, орлоготой байж эдийн засаг томорно. Эргээд л цалин авсан орлого чинь хэрэглээ болоод эдийн засгаа тэлж байдаг.

Тэгэхээр энэ дээр бид нэг дорвитойхон шиг дэмжлэг үзүүлж, бодлого гаргаж явахгүй бол. Анх гарсан хуулиараа жижиг, дунд бизнесийнх нь тодорхойлолт, хэмжээ хязгаарууд нь гацчихсан. Борлуулалтын орлого нь 1.5 тэрбум гээд. Үүнийгээ нэмэгдүүлэх хэрэгтэй. Түүнээс хойш Монгол Улсын эдийн засаг хэд дахин өсөв. Төсөв хэд дахин өсчөв.

Тэгэхээр бид үүнийгээ улс орныхоо эдийн засгийн өсөлт, инфляцтай холбогдуулаад зайлшгүй нэмэгдүүлэх хэрэгтэй.

Тэгэхээр энэ дээр Та бүгдийн яг хүсэж байгаа, төсөөлж байгаа судалгаа юу байна? Яг тавьж байгаа шаардлагаа яаж дараагийн түвшинд гаргах хэрэгтэй байна.

Хоёрт, зээл. 300 сая төгрөгийн зээл аваад үйлдвэрлэл босгоно гэдэг хэцүү шүү дээ. Нэг удаа аваад хийчихгүй. Энэ чинь урт хугацаанд. Тодорхой. Доор хаяж 2, 3 жил үйл ажиллагаа нь жигдэрч явдаг.

Тэгэхээр энэ дээр зээлийн хэмжээгээ ямар хэмжээнд нэмэгдүүлэх хэрэгцээ шаардлага байна аа? Ямар судалгаа байгаа вэ? Ийм зүйлийг л асуумаар байна.

Гуравт, ер нь манай Монгол Улс маш олон төсөл, хөтөлбөр маш олон сангаар дамжуулж зээлүүд өгдөг. Маш их дутагддаг зүйл нь ялангуяа жижиг, дунд бизнес дээр менежментийн чадварыг нь нэмэгдүүлж өгдөг. Санхүүжилтийг нь өгчихдөг.

Тэгээд эд нар чинь яг л том бизнес байна уу, жижиг бизнес байна уу ялгаа байхгүй санхүүгээ тооцох, хүний нөөцийн бодлого, засаглал гээд л ийм үйл ажиллагаануудад асуудалтай тулгардаг. Энэ бас алдагдалтай ажиллах, босож ирэхгүй бэрхшээл тулгарах нэг зүйл болдог. Энэ дээр тодорхой анхаарч ажиллагаанууд давхар явуулахгүй бол үр дүн муутай байх. Энэ дээр гаднын улсын жишээнүүд байж байдаг. Тухайлбал, Япон Улс компани нээхийн өмнө бүтэн сар сургалтад суулгаж байгаад ямар нөхцөл, ямар зах зээлтэй, ямар өрсөлдөөнтэй орчинд орох гэж байгаа юм, ямар эрсдэл үйлдэх юм ямар боломж байгаа юм гэдгийг нь ойлгуулж байгаад эхлүүлдэг. Үүн шиг иймэрхүү төрлийн зүйлүүдийг яаж хийхээр төлөвлөж байгаа вэ гэдэг зүйл байна.

Тэгээд эх үүсвэр дээр үнэхээр хангалтгүй. Нийт Монгол Улсад идэвхтэй үйл ажиллагаа явуулж байгаа 94 мянган байна. Түүний 67 хувь нь жижиг, дунд үйлдвэрлэл. Өөрөөр хэлбэл 63 мянган аж ахуйн нэгж байгаа. Тэднийхээ бид 0.4-хөн хувьд л зээлийг нь шийдэж өгч чадаж байна шүү дээ. Үүнийгээ бид доор хаяж жил болгон 5-аас 10 болгох хэрэгтэй. Эх үүсвэрийг нь нэмэгдүүлж. Энэ дээр Аж үйлдвэржилтийн байнгын хорооноос бодлогоо гаргаад Их Хурал дээр ч гэсэн бид төсвийг нь нэмэгдүүлэх тал дээр тод дуугарч ажиллах ёстой гэсэн ийм саналуудтай байна.

Тэгэхээр эх үүсвэр дээр та нар бас тодорхой төсөөллүүд байна уу? Зүгээр 500 тэрбум.../минут дуусав/

**С.Ганбаатар:** Тодруулчихъя. Тийм ээ. Ж.Энхбаяр сайд хариулъя. 5 номерын микрофонд.

**Ж.Энхбаяр:** 0.3 тэрбум буюу 300 сая төгрөг. Энэ дэндүү бага буюу маш бичил хэмжээний л дэмжлэгүүд.

Гэхдээ бас боломжийн. 5 хүртэл жил олгож байгаа юм. 300 сая төгрөг 5 жил. Тэгэхэд үйлчилгээ явуулж байгаа жижиг цехүүд, оёдлын, дарханы, мужааны үйлчилгээнийхэн хөөрхөн бас нэг тоног төхөөрөмжөө шинэчлээд, өнгө төрхөө сайжруулаад, бас байраа өргөтгөөд яг л тэр хэмжээнд.

Тэгээд борлуулалтын орлогыг нэлээн зайлшгүй нэмэхгүй бол. Ер нь тухайн үед энэ чинь 1 сая доллар дээр дүйцүүлж хийж байсан юм. Өнөөдрийн ханшаар сая доллар бол 3.5 тэрбум шүү дээ. Тэгэхдээ ядахдаа энэ түвшинд нь аваачиж хүргээд тэгээд зээл олгох хэмжээг нь жоохон босгох шаардлага байгаа.

Ахиад л ерөөсөө тэгээд л эх үүсвэр л дээ. Эх үүсвэр хийе. Одоо олгож байгаа энэ сангийн тухай хууль, энэ үйл ажиллагааны эрх зүйн реформыг Байнгын хороо маань санаачлаад хаврын чуулгандаа багтаж хийгээд 2026 оны төсөв батлах хүрээнд нэлээн бодлогын алхам хийчихэд хөөрхөн явчихна. Ер нь их сайн өгөөж өгөхөд бэлэн болж байгаа. Нийгмийн хандлага бол. Ийм л салбар болчихоод байна.

**С.Ганбаатар:** Менежментийн чадвар гэдгийг тодруулж асуусан. Тэрийг хариулъя.

**Ж.Энхбаяр:** Тэгээд л энэ бизнест сургах их томоохон ажлууд. Бизнесээ яаж төлөвлөх вэ, яаж хөдлөх вэ, санхүүгээ яаж хөтлөх вэ, яаж тайлагнах вэ, зах зээлийн судалгаа яаж хийх вэ гээд зөндөө л олон ажлууд байна.

Тэгээд энэ болгоныг хийхийн тулд л тэгээд л нөгөө түрүүний яриад байгаа нэг инкубатор төвтэй болчихъё гэж мөрөөдөөд байгаа нь тэр л дээ. Тэнд ирдэг. 2 долоо хоног ирээд вакуумжиж байгаад нэг бойждог. Нэлээн сайн сургалтаа авчхаад. Тэнд нь өөрийн мэргэжил, онцлог, нутаг оронд нь таарсан чиглэлийг нь өгөөд та бол ийм төгрөгийн бизнес, ийм төгрөгийн хэмжээнд явж болох юм байна, болохоор байна гээд нэг чиглүүлээд мөнгөө бүтээгээд тэр хүн диплом хамгаална гэдэг шиг зээлээд тэнд 14 хоног хамгаалаад гардаг.

Одоо бид төслөө аваад төслийн хүрээнд очоод барьцаа хөрөнгийн үнэлгээ хийгдээд тэгээд өгч байгаа шүү дээ. Тэгэхэд арай өөр ахисан түвшинд юм хийхэд бид тийм нэг сургалтын сургалтын инкубатор төв, бойжуулах төв зайлшгүй байгаа.

Энд зохицуулалт хийгээд бид нэг ашиглалт муу байгаа. Мэргэжил сургалтын үйлдвэрлэлийн төв, коллежууд янз янзын ийм боловсролын системийн байгууллагыг тулгуурлаад нэг шийдэх бололцоо уг нь байгаад байх шиг байгаа юм.

**С.Ганбаатар:** П.Ганзориг гишүүн тодруулж асууя.

**П.Ганзориг:** Бизнесийнх нь тэр менежментийн чадварыг сайжруулах маш чухал. Инкубатор төвийг байгуулаад явах ёстой. Тэгээд тодорхой хэмжээнд ямар орчинд, ямар зах зээлийн багтаамжтай орчинд өрсөлдөж байгаа юм бэ, ямар эрсдэлүүд байгаа юм бэ гэдгээ ойлгоод явах юм бол энэ зээлийн ашиг, үр шим нь маш сайн гарна. Тэгэхээр энэ дээр зайлшгүй их хэрэгтэй.

Би эндээс яг үүнтэй холбоотой тоо тодруулаад асуумаар байна. 2024 онд нийтдээ 278 байгууллагын төсөлд зээл өгсөн гэж байгаа юм. Яг үүний хэд нь ашигтай байна? Тайлангаараа.

Сүүлийн 3 жилийн хугацаанд 700 орчим зээл олгосон байна. Төслүүдэд. Яг хэдэн нь ашигтай байгаад байна. Үүнийг бас нэг зорилтоо болгож тавимаар байгаа юм.

Тэгээд одоо яах вэ, яалт ч байхгүй. Уг нь арилжааны банкууд үүнийгээ өгөөд явдаг. Дэлхийн улс орнууд тийм. Гэтэл харамсалтай нь манай арилжааны банкнуудаас жижиг, дунд бизнесүүд зээл авахын тулд зээл авах бараг шаардлагагүй гэдгээ нотлох болдог байхгүй юу. Ямар ч бизнесүүд. Тийм болохоор одоо бид энэ ЖДҮ-гийнхээ санг хөгжүүлээд явах хэрэгтэй.

Тэгээд тэр барьцааны асуудлыг сайн шийдэхгүй бол зээлийн.../минут дуусав/

**С.Ганбаатар:** Батлан даалтаа анхаарахгүй бол болохгүй гэдэг асуудал ярилаа. Энэ дээр нэмж тайлбар өгөх үү.

**Ж.Энхбаяр:** Эрх зүйн орчин боловсронгуй болгох хүрээндээ л хамтраад нэг дорвитойхон шиг хөдөлгөчихмөөр байгаа юм.

**С.Ганбаатар:** Ингээд ашигтай ажиллаж байгаа гэдэг дээр бас тодруулж нэг хариулах уу? 4 номерын микрофоныг нээж өгье.

**Я.Эрдэнэсайхан:** Сүүлийн 4 жилийн хугацаанд бид 960 аж ахуйн нэгжид 116 тэрбум төгрөгийн зээлийг өгсөн байгаа.

Энэ дээр бид 2020 онд журмаа өөрчлөхдөө түүнээс өмнө зээл өгөөд орхичихдог байсан. Одоо бид цогцоор нь дэмжихийг хичээж байгаа. Хүн хүч бага, төсөв хөрөнгө бага хэдий ч гэсэн ажиллаж байгаа. Өөрөөр хэлбэл зээлээ өгөхөөсөө өмнө сургалтуудыг хийж байгаа. Төслөө хэрхэн бичих гээд. Зээл авсных нь дараа жил бүр араас нь хяналт, мониторинг хийж байгаа. Тайланг нь улирал бүр авч байгаа.

Тэгэхээр зээл авсан аж ахуйн нэгжүүд өнөөдрийн байдлаар бүгд ашигтай ажиллаад сайн явж байгаа. Бид нарын дахин дахин сайд хэлээд байгаа юм бол үнэхээр үйл ажиллагаа харьцангуй маш сайн болсон. Одоо эх үүсвэр дутагдалтай учраас маш олон асуудал дээр түрүүний хэлээд байгаа ерөөсөө нийт байгаа аж ахуйн нэгжийн 0.1, 0.2-хон хувьд нь л зээл олгогдоод байгаа юм.

Монгол Улсын жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн жилийн хэрэгцээ гэхэд 2 их наяд байгаа юм.../минут дуусав/

**С.Ганбаатар:** 5 номерын микрофоныг нээж өгье.

**Ж.Энхбаяр:** Тэгээд бид яам Дарханд шилжсэнтэй холбоотойгоор Жижиг, дунд үйлдвэрийн газрынхан бид менежмент, үйл ажиллагаа, сургалт, сургалтын тэр орчин нэлээн л юм янзалсан.

Тэгээд Та бүхэн очих үед бас нэг сайхан танилцуулмаар байгаа юм. Ингэж бид хийж байна, ингэж сургалт өгч байна. Зээл хүссэн хүн ийм ийм дарааллаар, ингэж мэдээллийн сангаар, ийм программаар ашиглаад ингэдэг тэгдэг гээд.

Тэр үед бид салбарын дэлгэрэнгүй танилцуулгуудыг бүх салбараараа танилцуулах болно.

**С.Ганбаатар:** Ингээд гишүүд асуулт асуулаа. Би хэдэн тодруулах зүйлүүд байна. Тэрийгээ тодруулаад дараа нь гишүүд үг хэлнэ. Дараа нь ажлын хэсэг байгуулна. Энэ дээр.

Ингээд өмнөх хуралдаанаар байгаль орчны болон хүнс, хөдөө аж ахуйн байгууллагууд дээр яригдсан маш олон олон улсын зээл, тусламжуудын тухай ярьсан. Түүн дээр бид хариуцлага тооцно. Нэхэл хатуутай араас нь явна. Тэд нар нь ихэнх нь дуусаж байгаа хөтөлбөрүүд, дуусаж байгаа төслүүд.

Энэ бол эхэлж байгаа зүйл. Энэ дээр бид өмнө нь яваад, бас алдаа оноо байсан уу, эсвэл гажуудал байсан уу, хэлмэгдүүлэлт байсан уу. Яваад. Тэгээд дараа нь энэ Жижиг, дунд үйлдвэрлэлийн газар өөрөө бас реформ хийж, өөрөө шинэчлэгдэх гэж их хичээж байгаа яг энэ үед одоо манай Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооноос энэ дээр гар нийлж ажиллана. Энэ шинээр эхэлж байгаа зүйл.

Тэгээд хоёр хэлэх гол асуулт байна. “Саалиа бэлдэхээр саваа бэлд” гэгчээр мөнгө төгрөг л хэрэгтэй байна даа, мөнгө л өгчихвөл бидний ажил болчих гээд байна гэдэг дээр би өндөр акцент өгмөөргүй байна. Тэртээ тэргүй бид төсөв дээр энэ дээр уулгалан орохгүй бол Монголын ард түмэн жижиг, дунд үйлдвэрлэлээс л хамааралтай байгаа.

Тэгэхээр “саалиа бэлдэхээр саваа бэлд” гэдэг шиг тэр мөнгө төгрөг орж ирэхээс өмнө Жижиг, дунд үйлдвэрлэлийн газар дээр, одоо энэ бодлого дээр нэгдүгээр зүйл гэвэл эрх зүйн орчин дээр нь ямар ямар өөрчлөлтүүдийг хийх ёстой вэ гэдэг дээр бодлогын яам, жижиг, дунд үйлдвэрлэлийн газрууд тогтсон, судалсан яг ийм ийм реформуудыг бид хийх шаардлагатай байгаа гэдэг дээр

надад манай гишүүдэд нэг тодорхой хариулж өгөөч. Яг эрх зүй дээр ийм ийм реформууд байгаа.

Хоёрдугаар гол зүйл гэвэл зах зээлийн маркетингийн асуудал дээр би хоёр дахь зүйлээ гол хэлэх гэж байна. Юу гэвэл кластер хэрэгтэй. Аймаг, сумдууд ер нь төрөлжсөн байдлаар хөгжих ёстой л гэж яриад байгаа.

Яг ямар кластер вэ, ямар хөгжүүлэлт вэ, ямар төрөлжилт вэ гэдгийг сум болгон, аймаг болгон, бүс болгонд бодлогын яам нь гаргаж ирэхгүй бол гишүүд юм уу, эсвэл сайн дурын уран сайханчид юм уу, эсвэл зүгээр жижиг, дунд үйлдвэрлэлийг хийхийг хүсэж байгаа хөдөлмөрч жирийн нэг хүнд энэ хувь заяаг өгнө гэдэг бол бодлогын яамны шаардлагагүй болчихно.

Энэ тал дээр та нар юу хийсэн бэ? Энэ материалуудыг бид хэзээ авч болох вэ? Хоёрдугаар асуулт. Өөрөөр хэлбэл яг Орхон аймаг юугаар дагнах юм, Баянхонгор аймаг юугаар дагнах юм, сумдууд руугаа яаж тэрийгээ кластераа төрөлжүүлэлттэй хувааж байгаа юм гэдэг дээр мэргэжлийн байгууллагын дүгнэлт, судалгаа шинжилгээ бодлогын яамнаас гарах ёстой. Түүн дээр ямар материал байгаа вэ? Хэзээ бидэнд өгөх вэ?

Яг энэ асуудал дээр холбогдуулж test pilot гэж ярьж байгаа. Одоо ингээд хамгийн шилдэг туршлагаа бусад нь нялзаах гэдэг чинь л манай Самбуу даргын ганц хийдэг ажил шүү дээ.

Тэгэхээр яг энэ дээр адууны өөх тосоор саван хийгээд хүний ийм ийм биеийг өндөр болгож байна гэдэг юм яриад явж байгаа зүйлийг харлаа. Энэ одоо яг судалгаатай, үндэслэлтэй байгаа бол адуутай нутгуудад яагаад нялзааж болохгүй гэж. Ингэний сүүгээр гээд. Энэ дээр юу байгаа вэ? Миний хоёр дахь асуулт энэ шүү. Зах зээлийн маркетингийн асуулт асуучихлаа.

Гуравт нь, ямар ч ЖДҮ-лэгч технологийн шийдэл гаргана гэж байхгүй. Технологийг төр засаг, бодлогын яам, Дэлхийн худалдааны байгууллага, бүс нутгийн худалдааны байгууллага, Засгийн газрын хэлэлцээрт оруулж шийддэг.

Тэгэхээр энэ технологийн шийдлүүд дээр манай бодлогын яам ямар ямар шийдэл гаргасан юм? Эсвэл юу ч байхгүй юу? Байгаа бол бид тэрийг мэдэж болох уу? Гурав дахь зүйл.

Та нар Монгол орон даяараа энэ адууны хаягдаж байгаа жалгайныг тарж байгаа энэ дайвар бүтээгдэхүүнээр нохой, муурын хоол хийх ч юм уу, эсвэл тэр савангаа хийх технологи, шийдэл, маркетингийн гарцууд юу байгаа вэ гэдгийг би асуулаа.

- ▶ Нэгд, эрх зүйн орчин.
- ▶ Хоёрт, зах зээлийн судалгаа.
- ▶ Гуравт, технологи.
- ▶ Дөрөвт, хүний нөөцийн бодлого.

Энэ хөдөө аж ахуй, мал аж ахуйн гаралтай түүхий эдүүдийг боловсруулахад боловсон хүчний асуудал дээр, хүний нөөцийн асуудал дээр яг ямар шийдэл байгаа юм? Энэ олон талын нэг тарсан МСҮТ-үүд энэ дээр төвлөрөж байгаа юу? Яг энэ хөдөө аж ахуй, мал аж ахуйн гаралтай салбаруудын МСҮТ-үүдийг энэ салбарын яамдтай яаж уялдаж холбох юм бэ? Хүний нөөц дээр юм байна уу?

5 дахь асуулт. Миний сүүлийн асуулт. Тэгээд дуусна. Одоо ёстой нөгөө зээл рүүгээ орж байна даа. 5 дугаар асуудал шүү дээ.

Энэ 4 шийдчихвэл зээл тодорхой болно. Зээл өгөх гээд хүмүүс уралдаж ирнэ. Би мянган саван ГОК-д нийлүүлнэ гэх л юм бол тэгээд л маргааш ХААН банк надад зээл өгье гэж байгаа юм шүү дээ. Түүн шиг Япон руу бид адууны өөхөөр сая саван хийнэ гэдэг гэрээгээ оруулаад ирвэл ХААН банк маргааш надад зээл өгнө.

Түүнтэй адил зээлийн бодлого дээр. Одоо ний нуугүй хэлэхэд том том банкнууд жижиг, дунд үйлдвэрлэгчдийг ёстой үл ойшоож байгаа шүү дээ. Эд нараар яадаг юм. Надад том том хэдэн уул уурхайнууд байна. 5, 10 клиенттэй. Тэгээд л болсон. Жижиг, дунд үйлдвэрлэгчид үндсэндээ тэр өдрийн, цагийн зээл гэдэг рүүгээ л явж байгаа. Хадгаламж, зээлийн хоршоо руугаа л явж байгаа. Ийм бодлогын алдаа гарчхаад байхад бид та нарт ямар шийдэл байгаа вэ?

Жишээ нь, бусад улс орнуудад яг энэ хөдөө аж ахуй, мал аж ахуйтай орнуудад арилжааны банкны лиценз Монголбанкнаас авсан бол нийт зээлийн багцын 30-аас 40 хувь нь жижиг, дунд үйлдвэрлэгч байна. Тэр тодорхой хувь нь мал аж ахуй, газар тариалангийн бодлого руу орох ёстой шүү гэсэн тийм зэилийн бодлого явдаг. Одоо бол зүгээр л бүх банкнууд уул уурхай шүтэж амьдарч байгаа. Засгийн газар ч ялгаагүй. Яамдууд ч ялгаагүй. Ерөөсөө үнэхээр биеэ тоосон. Энэ жижиг дундыг бүр хаячихсан.

Тэгэхээр миний энэ 5 асуултад бодлогын хариулт өгөх боломж байна уу? Бид энэ дээр зүрх сэтгэлээсээ ажиллана та нартай. Бид дэмжиж ажиллана. Бид сэтгэлээрээ ажиллана. Яагаад гэвэл сонгогчдод жижиг, дунд үйлдвэрлэл л хэрэгтэй байна. Орлого хэрэгтэй байна. Ажлын байр хэрэгтэй.

Энэ уул уурхай, энэ олон архины үйлдвэрүүд цөм цөм орлого олдог, татвар төлдөг байж болно. Ажлын байрны гуравхан хувийг хангадаг.

Тэгэхэд нийт ажлын байрны 60, 70 хувийг хангаж байгаа мал аж ахуй, хөдөө аж ахуй дээр бид ийм арчаагүй байдалтай байж болохгүй гэж би бодож байна.

Миний 5 асуултад хариулт өгөх боломж байна уу?

4 номерын микрофон хариулт өгье.

**Я.Эрдэнэсайхан:** С.Ганбаатар гишүүний асуултад хариулъя.

Өнөөдөр эрх зүйн реформ хийх маш их шаардлагатай байгаа. Энэ хүрээнд жишээлбэл Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хууль, Татварын хууль, Зээлийн батлан даалтын сангийн тухай хууль, Засгийн газрын тусгай сангийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах зэрэг маш олон хуулиудад өөрчлөлт оруулж байж энэ жижиг, дундыгаа яг цогцоор нь дэмжих. Тэгэхгүй нэг хуульд өөрчлөлт орчихоор яг дэмжигдэж чадахгүй нэг газар очоод гацчихаад байгаа юм.

Байнгын хорооны гишүүд цогцоор нь шийдье гэж байгаад их баяртай байна.

Маш олон хуулиудад бид судалгаа, тооцоолол хийсэн байгаа. Гааль, НӨАТ-ын хууль гэх мэт.

Зах зээл, маркетингийг нээх тал дээр түрүүн хэлсэн. Маш бага хүчээр, маш бага нөөцөөр чадах чинээгээрээ ажиллаж байгаа. Энэ хүрээндээ түрүүн дотоодын 17, гадаадын 20 үзэсгэлэн зохион байгуулаад 30 гаруй тэрбум төгрөгийн борлуулалтын орлого хийсэн байна. Байнгын үйл ажиллагаатай 3 дэлгүүрийн тухай түрүүн тодорхой хэлсэн.

Бид экспортод гаргах чиглэлд нь явж байгаа аж ахуйн нэгжүүдийг дэмжих ийм сангийн эх үүсвэр нэмэгдсэн тохиолдолд ийм чиглэлийн бүтээгдэхүүн гаргахыг бас хүсэж байгаа.

Тэгэхээр мөн экспортын баталгааны сан өнөөдөр үнэхээр Монголд бас дутуу байгаа. Яг экспортод зорьж байгаа аж ахуйн нэгжүүд маш цөөхөн. 600, 700-хан байгаа. Эд нар дээр санхүүгийн асуудлыг нь хийсэн форвард хэлцэл юм уу. Тэрийг нь уялдуулж ингэж баталгаа гаргаж өгөөд, тэгээд орлогыг нь оруулдаг байх ийм баталгааны сангийн асуудал өнөөдөр ерөөсөө Монголд байхгүй.

Асуудлуудыг шийдэх шаардлагатай байгаа. Хүний нөөцийн хувьд өнөөдөр бүгд мэдэж байгаа. Халамж хэт их байгаа.

Тийм учраас жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчид ажиллах боловсон хүчин олдохгүй байгаа. Сургах нэг асуудал байгаа. Энэ бол коллеж, МСҮТ-д яг тэр ажлаа мэддэг хүмүүсийг нь ТУЗ-д нь, эсвэл хөтөлбөр боловсруулахад нь оруулаад яг тэндээс сургалтын программ нь гарсан тэр хүн нь яг тэр салбартай ажиллахын тулд юу мэдсэн байх ёстой вэ гэдгийг нь цогцоор нь хийж өгөхгүй бол яг өнөөдрийн хувьд боловсролын байгууллага нь тусдаа. Хүнсний гэдэг юм уу, хөнгөн гэдэг юм уу үйлдвэрийн бодлого нь өөр яаман дээр байхаар. Одоо Хөдөө аж ахуйн их сургуулийн хувьд гэхэд ингээд тус тусдаа байгаа учраас энэ судалгааны байгууллага, мэргэжлийн байгууллага ингэж уялдахгүй бас ийм дутагдалтай байгаа юм.

Тэгэхээр энэ дээр бас хууль эрх зүйн хувьд хийх шаардлага байгаа.

Үнэхээр жижиг, дунд үйлдвэрлэлийн хамгийн гол асуудал бол маш олон хүн өөрөө өөрийгөө, өөрийнхөө тэр жижиг, дунд үйлдвэрийн салбарт ажиллаж байгаа хүмүүсийг ажилтай, орлоготой байгаад, бид нарын нөгөө хэлж заншсанаар чинээлэг дундаж давхарга буюу бусдад дараа болохгүйгээр өөрийгөө болон ойр тойрныхоо хүмүүсийг авч явдаг ийм салбар.

Уул уурхай мэдээж их орлого оруулдаг, цөөхөн хүн. Дэлхийн улс орнууд өнөөдөр яагаад жижиг, дунд үйлдвэрийн салбартаа маш ихээр анхаараад эхлэв гэхээр энэ хүмүүст жоохон дэмжлэг өгчихвөл төрд ирж байгаа маш их дарамтыг тэд нар өөртөө шингээж аваад өөрсдөө асуудлаа шийдээд тэр гэмт хэрэг, ажлын байр, бүх асуудлыг тэр орон нутгийн хөгжилтэй шийдээд яваад байгаа. Хамгийн гол онцлог нь энэ дээр тулгуурлаж гарч ирж байгаа учраас жижиг, дунд үйлдвэрийнхээ салбар луу нэг хэсэг жоохон анхаарч өгөөд тэгээд өөрөө өөрийгөө тэжээгээд орон нутагтаа ажлын байраа бий болгоод үйлдвэрлэлээ хийгээд явах боломжуудыг үүсгэж байгаа юм.

Тэгэхээр энэ бол маш чухал гэж ингэж харж байгаа.

**С.Ганбаатар:** Ж.Энхбаяр сайд. 5 номерын микрофоныг нээж өгье.

**Ж.Энхбаяр:** 90-ээд онд Улаанбаатар хот ямар байсныг Та нар эргээд нэг санаарай. Бүгдээрээ. Өнөөдөр ямар байгаа билээ.

Энэ булан тохой болгонд асаж байгаа гэрэл бүгд манай жижиг, дунд үйлдвэрийнхэн. Ер нь дэлхийн байгаа бүх л үйлчилгээ хэрэглээг бий болгож чадсан. Хамгийн бага дэмжлэгтэйгээр хамгийн өөрсдийн идэвхтэй санал санаачилгаар хувь хүний манлайлал дээр яваад босоод ирлээ. Одоо нэг урагшлуулмаар байгаа юм. Одоо ялангуяа сүүлийн үед бид энэ үйлчилгээний салбар нэлээн овоо болчихлоо.

Одоо С.Ганбаатар даргын хэлдэг. Бид инновац, технологи нэвтрүүлэх энэ тал руугаа эд нарыгаа дараагийн түвшинд гаргах. Инновац нэвтрүүлэх, технологи эзэмшүүлэх, тэгээд бизнесийн хувьд бойжуулах нэг төвтэй болмоор байна.

Юм мэдэхгүй арван хэдтэй сургууль төгссөн хүүхдүүд авчраад бизнес заах биш. Одоо яг нарийн боовон дээр ажиллаж байгаа тэр 40 настай эмэгтэйд хамгийн сүүлийн үеийн тэр жорыг, хамгийн сүүлийн тэр ор дэлхий нийтэд гарч байгаа тэр чиг баримжаа, өөрчлөлтийг, амт, үнэр. Тэрийг нь зааж сургадаг ийм маягийн нөгөө юм хийж байгаа улсуудаа дахин хөгжүүлэлтийг нь шинэ шатад гаргах сургалт, инновацын төвтэй. Тэнд ирээд тэр хүн 2 долоо хоног дотуур байранд байгаад, илтгэл тайлангаа тавиад, өөрийнхөө жаргал түүхийг яриад, тэгээд мөнгөө босгож аваад гардаг. Яг ийм л шинэ түвшний л сургалтын юмтай л болмоор байгаа юм.

Тэгэхээр нь нэвтрүүлдэг салбарын тухайд хэлэхэд нэг ийм. Үнэхээр би бас хүч хүрэхгүй л байгаа нэг зүйл. Манай салбарын боловсон хүчний бодлого яамнаасаа тусдаа байдаг. Цагтаа 15 мянган оюутан бэлдэж байсан Хөдөө аж ахуйн их сургууль өнөөдөр 3 мянга хүрэхгүй оюутантай, салбарын боловсон хүчний нөөц маш дутуу, бэлтгэл хангалт байхгүй. Үндсэндээ насжилт өндөр болж байгаа.

Яамыг мэргэжлийн шинжлэх ухаанаар цэнэглэж байх ёстой манай 6 хүрээлэн байсан. Хөдөө аж ахуйн их сургуулиа хаяад одоо тусдаа яамны мэдэлд оччихсон. Хөгжлийн яам руу оччихсон.

Ингээд салбар өөрөө шинжлэх ухаангүй, хүний нөөцгүй. Бодит байдал маань энэ. Яаралтай үүнийг залруулж, хүний нөөц, салбар, шинжлэх ухаан, төрийн бодлого нэг цогц байж байж бид хөдлөхгүй бол ингээд энэ салбарыг олон тийш нь салгаад эрэмдэглэчихсэн байдал үнэхээр маш том саад болж байгаа гэдэг юм уу, юу гэдэг юм. Энэ ямар санаатай хийгдсэн нь би сайн ойлгодоггүй. Туйлын хортой нөлөөлж байна.

Энэ жил ийм технологиор ийм хөрсөнд ийм юм тарь гэж бид нарт, надад зааж, бид бодлого гаргаж байх ёстой тэр Газар тариалангийн хүрээлэн өнөөдөр тийм юм бид нарт хэлж өгөхгүй. Мал аж ахуйн өвчин эмгэг чинь ийм болоод байна. Ийм ийм юм зохион байгуулалт хий гэж хэлэх ёстой Мал аж ахуйн хүрээлэн байхгүй байгаа юм. Хамгийн олон эрдэмтэдтэй төсөвтэй байж л байна. Гэхдээ тэд Хөгжлийн яам руу оччихсон.

Уг нь ядахдаа Хөдөө аж ахуйн их сургуулийнхаа дэргэд байж байгаад их сургуулиа шинжлэх ухааны үндсээр хангаж байх ёстой хүрээлэнгүүд маань их сургуулиа орхиод явчихсан. Тэгээд шинжлэх ухаангүй Хөдөө аж ахуйн их сургууль болж хувирсан. Хүрээлэнгүй. Яам нь сургуульгүй болсон. Сургууль нь

хүрээлэнгүй болсон нэг ийм л завхарсан байдал. Үүнийг би завхрал гажуудал гэж хэлэх гэж байна.

Тэгэхээр бүгдээрээ саяын жижиг дуун дээр бол Я.Эрдэнэсайхан даргын хэлдэг шинэ тийм бойжуулах төвийг бид хийхэд арга ухаанаараа өөрөөр хийхэд бол өнөөдрийн яг энэ ажил хийж байгаа 64 мянган тэр бизнес эрхэлж байгаа улсуудаа дахин сургаж шинэ түвшинд гаргах чиглэлээр бид нэг дорвитой юм хийчихэд их хөөрхөн өгөөжтэй. Эд нарт урт хугацааны тийм жилийн сургалт хэрэггүй шүү дээ. 14 хоног яг сайхан вакум сургаад, тэгээд тэр олон улсын зээл хөтөлбөр, туршлага судлуулаад, гадаад дотоод танилцуулга хийдэг, танилцуулга илтгэл хийдэг. Сургаад. Эдийн засгийн үндэслэл тооцоо хийдэг сургаад шинэ түвшинд гарахад ер нь.../минут дуусав/

**С.Ганбаатар:** Би хариултаа авлаа. Өнөөдрийн хуралдаан яг Монголын ард түмэнд амин чухал хурал учраас ажлын албаныхан маань өнөөдөр энэ протоколыг сайн тэмдэглээд, бидний асуусан асуултад мэдээж 3, 4-хөн минут хариулах боломжгүй байгаа учраас та нар бусад гишүүдийн болон бүх гишүүдийн асуултуудыг бүгдийг нь бичээд сайдын нэр дээр явуулна шүү. Ойрын үед.

Тэгээд сайдын хэлдэг үнэн шүү дээ. Өнөөдөр малын зоо техник, мал эмнэлгийн ангид 20-хон хүүхэд орсон. 7-хон хүүхэд төгслөө гэж байгаа.

Тэгээд гараад ажиллаж байгаа нь хэд билээ. Энэ салбар тэр чигээрээ маш хүнд байдалд орчихсон байгаа. Энэ дээр бид шийдэл гаргахгүй бол өөр хөдөө аж ахуй нэг газар, Монголын хөдөө аж ахуй нэг газар энэ асуудлаар санаа зовоод хуралдаж байгаа хүмүүс хаана ч байхгүй. Бид л байгаа. Бид ачаагаа үүрэх ёстой.

Ингээд гишүүд асуулт асууж, хариултаа авлаа.

Ингээд одоо үг хэлэх гишүүд байвал нэрсээ өгнө үү? Ж.Энхбаяр сайд тодруулж хариулт өгье.

**Ж.Энхбаяр:** Байнгын хорооныхоо гишүүдийг яам урьж хүлээж авахад бэлэн байгаа.

Ер нь хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын нэг онцлог бол ерөөсөө цогц. Нэг салбаргүйгээр нөгөөдөх нь байхгүй. Газар тариалангүйгээр мал аж ахуй байхгүй. Мал аж ахуй байхгүйгээр энэ хөнгөн хүнсний үйлдвэрлэл байхгүй. Энэ жижиг, дунд үйлдвэрлэл энэ чинь бүгд ингээд цогц холбоотой юм байгаа юм.

Тэгэхээр энэ эко хүрээнд нь бид Та бүгдийгээ очиход юу хийж байгаа, юу санаж байгаа, салбарын нөхцөл байдал ямар байгаа, бидний бодит чадавх юу байна, эрх зүйн ямар өөрчлөх хэрэгтэй вэ гэсэн танилцуулгыг бид бэлдэж байгаа юм.

Тэгээд чуулган завсарлах гэж байна. Тэгээд завсарлагааны үеэр хүрэлцэн ирээрэй. Бид бэлэн хүлээж авахад бэлэн байгаа шүү. Тэгээд тэр цаг хугацаагаа бид нарт хэлэхийг хүсэж байна. Баярлалаа.

**С.Ганбаатар:** Ингээд яамныхаа хамт олны хийж хэрэгжүүлж байгаа, зорьж байгаа, мөрөөдөж байгаа олон зүйл дээр бид бас гар нийлж ажиллах ёстой. Тэгээд удахгүй очно.

Ингээд санал хэлэхийг хүсэж байгаа гишүүд нэрсээ өгчихсөн үү. Г.Лувсанжамц гишүүн дахиад нэг дарчхаарай. Тийм. Санал хэлнэ шүү. Тийм. Яаманд хэлнэ шүү.

С.Замира гишүүнээр үг хэлэх гишүүд дууслаа. Ингээд Д.Үүрийнтуяа гишүүн үг хэлнэ.

**Д.Үүрийнтуяа:** Баярлалаа. Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгч эрхлэгчдийн энэ нөгөө ангилал гээд байгаа. Тийм ээ. Ямар хэмжээний борлуулалттай бол гэдгээр.

- ▶ 300 сая төгрөг хүртэл жилийн борлуулалттай бол “бичил”,
- ▶ 300-аас тэрбум бол “жижиг”,
- ▶ 1 тэрбумаас 2.5 тэрбумын борлуулалтын орлоготой бол “дунд үйлдвэрлэл” гэж үзнэ гээд.

Тэгээд Та бүхний танилцуулгын ард аж ахуйн нэгжүүдийн хүний тоотой холбоотой нэг судалгаа байгаа юм. Нийт аж ахуйн нэгжүүдийн дийлэнх нь буюу 2023 онд гэхэд нийт салбарт байгаа 76 мянга 500 хүнээс 71 мянга 500 нь ерөөсөө 1-ээс 9 ажилтантай аж ахуйн нэгж байгаа байхгүй юу.

Энэ юуг илэрхийлээд байна гэхээр ерөөсөө бичил түвшинд л манай жижиг, дунд үйлдвэрлэл яваад байна.

9 ажилтантай гээд тооцоход сарын цалингийн зардлыг сая төгрөгөөр. Хөдөө аж ахуйн салбар дээр 1 сая төгрөг дундаж байгаа байх. 900-аас 1 сая төгрөгийн.

Тэгэхэд чинь үндсэндээ 9, 10 сая төгрөг нь борлуулалтын орлогын 25 сая төгрөгийн тал нь цалинд явах нь байна шүү дээ.

Тэгэхээр бид ангиллын авч үзэх цаг нь болчихсон юм биш үү. Яг энэ борлуулалтын орлогоор тооцоод байгаа хэмжээгээ авч үзэх цаг нь болчихсон юм биш үү. Өнөөдөр бид инфляц, үнийн өсөлттэй холбогдуулаад ажил, үйлчилгээний төсөвт өртгийг нэмээд байдаг. Яг аж ахуйн нэгжийг борлуулалтын орлогоор нь үнэлэх хэмжүүр, шалгуур үзүүлэлтүүд маань яг хэвээрээ байгаа нь хэр зохимжтой юм бол гэсэн ийм зүйл бодогдоод байгаа юм.

Хоёрдугаарт, жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжихийн тулд бид тэр кластерын зарчмаар дунд нь жижгийгээ, бичил бизнесээ дэмждэг. Дээр нь хөнгөн үйлдвэрүүд нь өөрсдөө жижиг, дунд үйлдвэртэйгээ хоршиж хамтарч ажиллах боломжуудыг гаргах гарц гаргалгаа, хууль эрх зүйн орчин дутагдалтай байна уу гэж ажиглагдаад байгаа юм л даа.

Нөгөө талдаа энд хамгийн чухал дэмжлэг бол борлуулалтын дэмжлэг. Борлуулалтын дэмжлэг дээр түрүүн асуулт дээр Б.Пунсалмаа гишүүн ярина лээ. Төрийн худалдан авах ажиллагааны хуультай холбоотой.

Тэгээд өнөөдөр Монголд хамгийн том худалдан авагч хэн бэ. Хамгийн том худалдан авагч өнөөдрийн эдийн засаг дээр төр өөрөө л байгаа байхгүй юу. Яагаад гэхээр тийм том хэмжээний худалдан авагчтай бизнесийн салбараа бид хөгжүүлж чадаагүй.

Тэгээд яг энэ нөхцөлд жижиг, дунд үйлдвэрлэлээ дэмжье гэвэл Төрийн худалдан авах ажиллагааны хуулиа өөрчлөхөөс өөр арга байхгүй.

Тэгэхээр эдийн засаг төрөөс хэт ийм хамааралтай байгаа үед Төрийн худалдан авах ажиллагааны тухай хуульд өөрчлөлт оруулаад ядаж сумын малчин иргэд, хоршоологч нар, энэ бичил бизнес эрхлэгчид маань сумандаа байгаа тэр сургууль, цэцэрлэг, эмнэлэг гээд л гурван хүнсний бүтээгдэхүүн худалдаж авдаг, түүгээр хоол унд хийдэг байгууллага байгууллага байна шүү дээ. Бүх суманд нь байж байгаа. Үүндээ ядаж тэр малчин өрх тариаланчид маань хүнсээ өгдөг хууль эрх зүйн орчныг л бид бүрдүүлж байж орон нутагт жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих тухай л асуудал яригдахгүй бол өнөөдөр нөгөө тендерийн хуулиар бүх зүйлийг зохицуулчихаад, тэгээд тендерийн босго жижиг, дунд үйлдвэрлэгчдийнхээ өмнө их өндөр шалгуур тавьчихаад явах юм бол энэ нөхцөл байдал хаана хаанаа хэрэгжихгүй болчихоод байгаа юм.

Тэгэхээр цогцоор нь авч үзэх юм бол Монгол Улсын Ерөнхийлөгчийн хэлж байгаа концепт, бодлого байдаг. Хөрс эрүүл бол хүнс эрүүл, хүнс эрүүл бол хүн эрүүл гэж.

Тэгэхээр хөдөө аж ахуйн салбар, ялангуяа жижиг, дунд үйлдвэрлэл, хүнстэй холбоотой бүтээгдэхүүний үйлдвэрлэл эрхэлж байгаа бодлого манай хүн амын хүнсний аюулгүй байдал, эрүүл ахуйтэй холбоотой, эрүүл мэндтэй

холбоотой суурь болж явж байгаа учраас цогцоор нь тал талаас нь авч үзэж шийдэл өөрчлөлтүүдийг гаргаж, тулгамдаж байгаа асуудлуудаа үе шаттайгаар чеклээд шийдвэрлээд явах энэ төлөвлөлт планаа Байнгын хороодтойгоо хамтарч хийх нь зүйтэй болов уу л гэсэн ийм саналтай байгаа гэдгээ хэлье.

**С.Ганбаатар:** Д.Үүрийнтуяа гишүүн үг хэлж дууслаа. Ингээд Г.Очирбат гишүүн үг хэлнэ.

**Г.Очирбат:** Юуны түрүүнд Ж.Энхбаяр сайддаа дэлгэрэнгүй сайхан танилцуулга хийсэнд маш их баярлалаа. Мөн дээрээс нь Жижиг, дунд үйлдвэрлэлийн дэмжих сан, газрынхан, энэ хариуцлагатай алба хаагч нарт бас баярлалаа гэж хэлэх гэсэн юм.

Манай энэ жижиг, дунд үйлдвэрлэлийн салбар бол өөрөө Монгол Улсын хөгжлийн суурь болж явах ёстой.

Тэгэхээр бид бас энэ Аж үйлдвэржилтийн байнгын хороонд байгаа. Хорооныхоо гишүүний хувиар Ж.Энхбаяр сайд аа, дэмжиж ажиллана. Бүх тал дээр нь дэмжиж ажиллана. Ялангуяа 2024-2028 оны хамтарсан Засгийн газрын мөрийн хөтөлбөрт жижиг, дунд үйлдвэрлэлтэй холбоотой ажил, санал санаачилгууд байгаа.

Тэгэхээр бид тодорхой түрүүний хэлдэг асуудлуудыг яг гаргаж ирж тавиад ард нь гараад, гараад явах л ийм он жилүүд хүлээгдэж байгаа. Тэгэхгүй бол энэ дээр улс төржөөд, дахиад бие биеийгээ янз бүрээр яриад, болж байгаа асуудлуудыг гацаадаг ийм цаг хугацааг хойноо тавиад, одоо бол яг шинэ мөрөөс энэ жижиг, дунд үйлдвэрлэл буюу энэ аж үйлдвэрийн салбарын түүхийг бас бичих цаг хугацаа ирж байгаа гэж харж байгаа шүү.

Тэгээд үүнийг бас манлайлж хийж байгаа Ж.Энхбаяр сайддаа амжилт хүсье.

Мэргэжлийн яаман дээр очиж ажиллана. Өөрийнхөө чиглэлээс ямар нэгэн тусалж дэмжлэг, эрх зүйн орчин, бүх тал дээр дэмжиж ажиллана гэдгээ илэрхийлье. Тэгээд Та бүхэндээ амжилт хүсье. Баярлалаа.

**С.Ганбаатар:** Г.Лувсанжамц гишүүн үг хэлнэ.

**Г.Лувсанжамц:** Ингээд төсвийн хэлэлцүүлгийн үеэр Ж.Энхбаяр сайдтай хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлтийн талаар нэлээн асуулт тавиад тусгайлан мэдээлэл өгнө гээд хэлсэн үгэндээ хүрээд Жижиг, дунд үйлдвэрлэлийн сангийн тайланг ингэж дэлгэрэнгүй байдлаар танилцуулж байгаад баярлалаа.

Сая асуулт дээрээ дурдсан. Зорилтот бүлэг гэдэг зүйлээ тодорхойлох маш их шаардлагатай байна. Бас зорилтот салбар.

Зорилтот бүлэг дээрээ 40-өөс доош насныхан буюу залуу үеийг оруулж өгөөч. Бид нарт ерөөсөө халамж, тэтгэмж, тэтгэвэр хэрэггүй. Боломж л хэрэгтэй байгаа юм.

Та бүхний энэ тайлан дээр байна шүү дээ. 7 сая төгрөгөөр нэг ажлын байрыг бий болгож, эсвэл хадгалж чадаж байгаа. Том зорилт тавиад 4 жилийн хугацаанд 1 их наяд төгрөгийг Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих сан дээр тавья. Жилдээ 250 тэрбум төгрөг. Нийтдээ 4 жилийн хугацаанд 160 мянган ажлын байр бий болох байхгүй юу.

Одоо гадаадад амьдарч байгаа залуучууд 100 гаруй мянга байгаа. Эд нар бүгдээрээ буцаад ирэх боломжтой болно. Зөвхөн дотоодоосоо зээл авахаар хандаж байгаа компаниуд гэлтгүй гадаадад байгаа залуучуудыг буцаж ирэхэд нь, Монголын эдийн засагт хувь нэмрээ оруулахад нь, гадаадад хүний доор ажиллах биш эх орондоо бизнестэй, ажилтай, орлоготой, амьдрах боломжийг нь бүрдүүлж өгөөч ээ гэсэн тийм зорилготойгоор саналаа хэлж байна.

Хоёрдугаарт нь, зорилтот салбараа тодорхойлох ёстой. Барилгын салбар дээр анхаарах хэрэгтэй байгаа юм. Жижиг, дунд үйлдвэрлэлийн 2023 оны тайлангаас уншихад барилгын салбар 11-хэн хувь байгаа юм. Манай улс үнэхээр бүсчилсэн хөгжлөө хийгээд, Улаанбаатар утаагаа шийдээд, залуучууд орон сууцтай болохын тулд энэ доор хаяж 25 хувь байх ёстой.

Тэгэхээр зорилго, зорилтуудаа тавих гэж байгаа бол сая хэлсэн зорилтот бүлэг насаар нь харах зорилтот салбараа тодорхойлоод, Ж.Энхбаяр сайдын сая хэлж байгаа шиг цогц бодлого хэрэгтэй гэдэг дээр. Тэгээд зорилтот салбараа барилгын салбар гэж тодорхойлж байгаад л Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдтайгаа хамтарч ажиллах ч байдаг юм уу. Тийм ээ. Залуучууд бизнес эрхлэхэд нь хэрвээ технологийн боловсрол, чанарыг дээшлүүлэх, эсвэл бизнесийн менежментийн боловсрол хэрэгтэй байгаа бол тэр тал дээр нь Боловсролын яамныхаа сайдтай цуг хамтарч ажилладаг ч байдаг юм уу. Засгийн газар талдаа Та бүхэн ингээд хамтраад ажиллаач ээ гэсэн тийм хүсэлт байна.

Их Хурлын гишүүний зүгээс ялангуяа залуу үеийн төлөөлөл болж байгаа хүний хувьд би Та бүхнийг нээлттэйгээр бүрэн дэмжиж ажиллая. Та бүхэнд та сая яаман дээрээ урьж байна. Хэзээ ч байсан хамаагүй очно би.

Дахиад нэг санал байна. М.Бадамсүрэн гишүүний ахлуулах гэж байгаа байгуулах энэ Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн ажлын хэсэг дээр бас би орж ажиллах хүсэлтэй байна.

Ж.Энхбаяр сайдтай маш их яриа нийлдэг сайдуудын нэг л дээ. Манай сайд бол “нэг суурин нэг бүтээгдэхүүн”, value chain буюу чанарын хэлхээ, бүсчилсэн хөгжил, кластержуулж хөгжүүлэх гэдэг дээр маш олон зүйл дээр санал нийлдэг. Олон улсад бас ийм төслүүд дээр ажиллаж байсан хүний хувьд гар нийлж ажиллах тийм хүсэл зорилго байна.

Тэгээд Та бүхний ажилд өндрөөс өндөр амжилт хүсье. Дараа нь хэлсэн шалгуур үзүүлэлтүүд буюу хөрөнгийн өгөөж, хөрөнгө оруулалтын өгөөж, нэг ажлын байрыг хадгалахад зарцуулж байгаа хөрөнгө. Эд нарыг төсвийн 1 дүгээр хавсралт дээр заавал тусгаж өгөөч ээ. Тэгж байж бид энэ төсвийн зарцуулалтыг, хөнгөлөлттэй зээлийн зарцуулалтыг чанартай байгаа, үгүйг, залуучууддаа хүрч байгаагүй, үгүйг хэмжих боломж бүрдэнэ. Баярлалаа.

**С.Ганбаатар:** Г.Лувсанжамц гишүүнд баярлалаа. Ингээд С.Замира гишүүн үг хэлнэ.

**С.Замира:** Чөлөөт холбоогийн нэг юм бас хэлчих гээд байна л даа. Би. Нэгэнт Хөдөө аж ахуйн яамны сайд байгаа юм чинь.

Таны ярьснаар хөдөө аж ахуйн сургууль нь төгсөнө. Мэргэжилтэн байхгүй. Тэгээд хажууд нь байгаа, үйл ажиллагаа явж байгаа бүх юм нь бараг сөнөсөн маягтай ярьж байна. Тийм ээ. Тэгээд мал эмнэлэгт Та өөрөө байсан билүү. Мал эмнэлгийн сонсгол дээр. Б.Бейсен дарга сууж байна. Мал эмнэлгийн дарга ерөөсөө утсаа авахгүй байна гээд.

Ингээд ер нь бидний амьжиргааны эх үүсвэр, тэгээд ЖДҮ-гийн эх үүсвэр нь шүү дээ. Энэ арьс боловсруулах үйлдвэр яснаас юм гаргаж авч болно, саван хийж болно, янз янз юм хийхэд хамгийн гол эх үүсвэр мал шүү дээ.

Тэгээд үүнийг та яая гэж бодож байна. Ер нь. Ингээд мал аж ахуйгаа ингээд байлгаад байх юм уу. Эсвэл нэг цогц том бодлого хэрэгжүүлээд энэ малаа эрүүлжүүлээд, газар хөрс эрүүлжүүлээд, энэ хүмүүс бас хорт хавдраар их өвдөж байгаа шүү дээ. Энэ малд хамаагүй тариа тарьдаг. Янз янзын юм бид сонсгол дээр сонссон шүү дээ. Энэ тал дээр танд ер нь санаа бодол байвал. Нэгэнт ингээд Аж үйлдвэржилтийн байнгын хороо хуралдаж байхад санаа оноо, дэмжлэг авахаар юм байвал. Хоёр Байнгын хороо бас хамтарч хуралдсан. Өчигдөр. Та байгаагүй.

Тэгээд ийм том юм бас бодох л хэрэгтэй. Хамгийн гол нь бид малаа, ард түмнээ хамгаалах хэрэгтэй. Эрүүл хамгаалалт хэрэгтэй. Тэгээд жижиг, дунд үйлдвэрлэл энд бас холбоотой.

Тэгээд Жижиг, дунд үйлдвэрийн санд гэж хэлэхэд түрүүн бас та нарт ярьж байсан. Икс тайлантай олон аж ахуйн нэгжүүд байна. Дунд давхарга. Алга болсон.

Түрүүн нөгөө Сангийн яамны сайдын ярьж байхыг сонсоход нөгөө ТОП-100 гээд байна шүү дээ. Тэд нар ердөөсөө ажилгүйчүүдийн дөнгөж 10 хувийг хангана гэнэ. Цаад талд нь үлдсэн 90 хувийг нь жижиг, дунд бизнес эрхлэгчид дунд давхарга хангадаг байсан. Энэ бүгд дампуурчхаад тэгээд ажилгүйдэл ихэслээ гээд тэгж байна.

Тэгээд тэрнийг одоо яах вэ. Сая нөгөө барьцаа хөрөнгө гээд яриад байна. Янз янз юм яригдаад байна шүү дээ.

Тэгээд энэ банкаар заавал дамжуулах ёстой юм уу, дамжуулахгүйгээр явуулах ямар боломж байна. Хөнгөлөлттэй зээл гадаадаас татах ямар боломж байна. Та мэдэж байгаа. Та бүхэн бүх улс орнууд дайн дажин, бас тэгээд байгалийн гамшиг хэрээсээ хэтэрсэн. Монгол орон шиг тайван оронд ямар ч хүмүүс хөрөнгө оруулалт оруулахад бэлэн байна гэж боддог юм.

Тийм учраас тэр тал дээр зөвхөн төрийн хэдэн төгрөг гаргах гаргахгүйгээр бас нэг том юм сэдвэл яасан юм бэ. Болох уу. Байнгын хорооны дарга.

Одоо Их Хуралд хүртэл асуудал оруулаад бид энэ жижиг, дунд үйлдвэрлэл хөгжүүлэх банк юм уу, гадаадын. Тийм ээ. Ямар нэг сантай хамтрах юм уу. Тэгж заавал нэг төрийн гар харахгүйгээр бид бас хажуугаас нь том том асуудал оруулаад тэрийг хиймээр байна шүү дээ. Монголын одоогийн банкны хүүгээр хэн ч хөдөлж чадахгүй.

Тэгээд одоо энэ ЖДҮ-ээс дамжаад нөгөө хүмүүст өгч байгаа зээл нь ямар хүнд очиж байгаа юм. Хүмүүсийн гарт. Банк бас арилжааны банк юу дэмжинэ шүү дээ. Сая уг нь би нэмж асуух гэж байгаад тэгээд орхигдсон. Энэ асуудлууд.

Тийм учраас ийм ийм санаа хэлмээр байна, дэмжмээр байна. Одоо ингээд парламентын бүлгэмүүдэд бид бас 5 улсад парламентын бүлгэмд бас хамрагдсан байгаад байгаа. Тэр хүмүүстээ бас хүсэлт тавьж юм хийж болж байна.

Тэгээд ямар санаа оноо байна. Та та бүгдийг нь хэлээрэй.

**С.Ганбаатар:** С.Замира гишүүн чухал санал хэллээ.

Ингээд энэ саналуудыг хуралдааны дараа ажлын хэсэг байгуулагдаад ажлын хэсэгтээ тусгаж ажиллана шүү. Тийм. Чухал саналууд байна.

Би ч ер нь С.Замира гээд гоё нэр, их цэвэрхэн дуудаж байх шиг байна. Би бол. Одоо тэрийг байн байн дуудах их дуртай. С.Замира гишүүн их сайхан үг хэллээ. Баярлаж байна. Тийм. Өнөөдөр ингээд С.Замира. Үгүй мөн гоё байна. Нэр бол агуу юм.

Ингээд Ж.Энхбаяр сайдад, мөн яамны хамт олонд жижиг, дунд үйлдвэрлэлийн төлөө зүрх сэтгэлээ өгч ажиллаж байгаа хамт олон өнөөдөр мэдээлэл хийлээ.

Ингээд бид бас Монголын ард түмний хамгийн хүсэн хүлээж байгаа. Ер нь Засгийн газар Монголын ард түмний өмнө хамгийн гол тулгамдаж байгаа юм ажлын байр, орлого.

Үүнийг шийдэх юм бол жижиг, дунд үйлдвэрлэлийн том үйл ажиллагаануудаа. Ингээд бидэнд мэдээлэл өгч, сонсож, гишүүд асуулт асууж, хариулт авч, үг хэллээ.

Ингээд өнөөдрийн эхний хэлэлцэх асуудал өндөрлөж байна. Хүнс, хөдөө аж ахуйн яамны хамт олондоо баярлалаа.

Дараагийн хэлэлцэх асуудалдаа орьё.

---

**Хоёр.Байнгын хорооны тогтоолын төсөл**  
/Ажлын хэсэг байгуулах тухай/

---

Дараагийн хэлэлцэх асуудал бол нэг их удахгүй. С.Замира гишүүн байж байна шүү. Би хэлэх дуртай болчих юм. Бүр гоё хэлээд байх шиг л байгаа. Тийм.

Хэлэлцэх асуудлын хоёрт Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хуулийн хэрэгжилт болон Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн эх үүсвэрийн бүрдүүлэлт, зээл олголт, эргэн төлөлт, зээлийн хэрэгжилт, үр дүнгийн талаарх мэдээллийг Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцсэнтэй холбогдуулан жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих, хөгжүүлэх бодлогын хүрээнд холбогдох санал, дүгнэлт гаргах, шийдвэрийн төсөл боловсруулах үүрэг бүхий “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцье.

Ингээд Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 116 дугаар зүйлд заасны дагуу Байнгын хорооны хуралдаанаар дээрх мэдээллийг хэлэлцсэнтэй холбогдуулан Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих, хөгжүүлэх бодлогын хүрээнд холбогдох санал, дүгнэлт гаргах, шийдвэрийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг байгууллагаар тогтсоны дагуу

---

тогтоолын төслийг боловсруулж Та бүхэнд тараасан байгаа. Гишүүд бүгдээрээ үзсэн байх. Тийм ээ. Тогтоолын төсөлтэй танилцсан байх.

Ингээд тогтоолын төслийг Та бүхэнд уншиж танилцуулна.

Монгол Улсын Их Хурлын Байнгын хорооны тогтоол.

“Ажлын хэсэг байгуулах тухай”

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3.3 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсгийг үндэслэн Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооноос ТОГТООХ нь:

1.Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хуулийн хэрэгжилт болон Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн эх үүсвэрийн бүрдүүлэлт, зээл олголт, эргэн төлөлт, зээлийн хэрэгжилт, үр дүнгийн талаарх мэдээллийг Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцсэнтэй холбогдуулан жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих, хөгжүүлэх бодлогын хүрээнд холбогдох санал, дүгнэлт гаргах, шийдвэрийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай:

**Ажлын хэсгийн ахлагч:**

М.Бадамсүрэн -Улсын Их Хурлын гишүүн

**Гишүүд:**

|             |                         |
|-------------|-------------------------|
| П.Ганзориг  | -Улсын Их Хурлын гишүүн |
| Х.Жангабыл  | -Улсын Их Хурлын гишүүн |
| Г.Очирбат   | -Улсын Их Хурлын гишүүн |
| Д.Энхтүвшин | -Улсын Их Хурлын гишүүн |
| М.Энхцэцэг  | -Улсын Их Хурлын гишүүн |
| Д.Энхтуяа   | -Улсын Их Хурлын гишүүн |

Д.Үүрийнтуяа гишүүн саналаа сая өгсөн, Далайн Батбаяр гишүүн саналаа өгсөн, С.Замира гишүүн саналаа өгсөн, Г.Лувсанжамц гишүүн бас саналаа өгсөн.

Ингээд Б.Пунсалмаа гишүүн саналаа бас өгч байна.

2.Ажлын хэсэгт мэргэжил, арга зүйн туслалцаа авах чиглэлээр холбогдох салбарын мэргэжилтэн, шинжээчдийг оролцуулж ажиллуулахыг ажлын хэсэгт /М.Бадамсүрэн/-д зөвшөөрсүгэй.

Аж үйлдвэрчдийн бодлогын байнгын хорооны дарга С.Ганбаатар гэсэн ийм ажлын хэсэг байгуулах Тогтоолын төслийг Та бүхэнд танилцуулж байна.

Төсөлтэй холбогдуулан асуулт асуух, үг хэлэх, үг хэлэх гишүүд байна уу? М.Бадамсүрэн гишүүнээр тасаллаа. Ингээд М.Бадамсүрэн гишүүн асуулт асууж, үг хэлнэ. Зүгээр үг хэлэх юм уу.

**М.Бадамсүрэн:** Энэ “жигжиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих” гэдгийн урд талд “өрхийн үйлдвэрлэл, бичил” гэдэг үгийг нэмбэл ямар вэ гэсэн санал байгаа юм. “Өрхийн аж ахуй, бичил” гэдэг үгийг. Тэгэхгүй өвхөн жигжиг, дунд үйлдвэрлэл гэдэгтэй ингээд хайрцаглагдах гээд байгаа. Тийм. Нэг.

Хоёрт нь, М.Ганхүлэг гишүүн бас энэ ажлын хэсэгт оролцъё. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн дэд сайдаар ажиллаж байсны хувьд залуучуудын төлөөллийн хувьд гэсэн санал өгсөн байгаа.

**С.Ганбаатар:** М.Ганхүлэг гишүүнийг бас оролцуулъя.

Одоо тогтоолын төсөл батлагдсаны дараа гишүүд орох болохоор ахиад хуралдах хэрэг гардаг юм шүү. Энэ чинь тогтоолд өөрчлөлт оруулах гээд.

Ингээд М.Ганхуяг гишүүний нэрийг бас нэмж оруулж байна.

Энэ дээр надад хоёр санал байна. Тэрийгээ хэлээд оруулчихъя. Түрүүн нөхдүүдэд би нэлээн саналаа хэлсэн байгаа.

Нэгдүгээрт, жигжиг, дунд үйлдвэрлэл, бичил болон өрхийн аж ахуй гэж орууллаа шүү.

Дээр нь нэмээд энэ дээр жигжиг, дунд үйлдвэрлэл болон үйлчилгээг дэмжихдээ кластераар хөгжүүлнэ л гэж яриад байгаа. Бүсчилсэн хөгжил хийнэ. Сум, аймаг, бүс болгонд, Улаанбаатар хот болон бусад Дархан, Эрдэнэт бүс болгонд ямар ямар зах зээлийн судалгаа хийж өгсөн юм, ямар ямар боломжит мэргэжлийн байгууллагуудын судалгаа шинжилгээг бодлогоор хийсэн юм бэ, бодлогын яам нь үүнийг гаргаж өг гэдэг энэ асуудлаа эндээ оруулахгүй бол болохгүй шүү.

Үүнийг чинь гишүүд та нар ингээд л нэг иргэдийн Хурлын Төлөөлөгч нартайгаа ярьж байгаад шийдчихээч ээ л гээд байвал үүн шиг мэргэжлийн бус зүйл байхгүй. Монгол орон 30 жил хэдэн трактор өгдөг, хэдэн хүлэмж өгдөг. Тэгчхээд л хөдөө аж ахуй хөгжихгүй байна гэж яваад байдаг чинь бодлогогүй яваад байгаа байхгүй юу.

Тэгэхээр удирдамж дээр эдгээрийг дэлгэрүүлж оруулна шүү. Бичил өрх гэж орлоо. Зах зээлийн тухай би ярилаа. Түрүүнээс хойш яриад байсан хүний нөөцийн талаар бас бид энэ дээр судалгаа хийх ёстой шүү.

Одоо энэ мал аж ахуй, хөдөө аж ахуй жижиг, дунд үйлдвэрлэл тэр чигтээ хүний нөөцгүй болчихсон. Толгойгоо барьж байгаа.

Тэгээд гурав дахь зүйл гэвэл технологийн шийдлийг яг бодлогын яам яаж гаргаж байгаа юм. Технологийн шийдлүүдийг Засгийн газар хоорондын хэлэлцээрүүдээр явдаг.

Ийм гурван зүйл. Татвар гэхлээр өөр Байнгын хорооны асуудал руу орчих гээд байгаа учраас би татвараа үлдээгээд энэ асуудлуудыг бас удирдамж дээр болон ажлын хэсэгтээ оруулахыг би санал болгож, үг үг хэлэхдээ оруулж байна.

Ингээд “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төсөлд гишүүд саналуудаа хэллээ. Энэ саналуудыг оруулаад тогтоолын төслийг баталъя гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. /алх цохив/

60.0 хувиар тогтоолын төсөл батлагдлаа.

Ингээд Байнгын хорооны өнөөдрийн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг дууссан тул хуралдаан өндөрлөснийг мэдэгдье.

Хуралдаанд идэвхтэй оролцсон Улсын Их Хурлын гишүүддээ баярлалаа. Ялангуяа С.Замира гишүүнд бүр их баярлалаа. /алх цохив/

Хуралдаан 2 цаг 04 минут үргэлжилж, 20 цаг 35 минутад өндөрлөв.

**БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ  
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,  
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ**

**Ц.АЛТАН-ОД**